



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.01.23 №03 (10680)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн Ц.ЭНХ-ОРГИЛ

ЭЛЧИН САЙД КОБАЯШИ ХИРОЮКИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



хаагчдыг оролцуулах зэрэг олон чиглэлээр амжилттай хөгжиж байгааг дурдав. Мөн хоёр орон харилцан цэргийн атташе томилон ажиллуулж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийллээ. Тэрээр цааш нь “Өнгөрсөн оны 12 дугаар сард Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны цэргийн хамтын ажиллагаа, “Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр” - ий г

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюкиг Төрийн ордонд хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Н.Энхболд хоёр орны хооронд байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд Монгол, Японы Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд бүх түвшний харилцан айлчлал, солилцоог хэрэгжүүлэх, зөвлөлдөх уулзалт, цэргийн боловсон хүчнийг сургах, Япон улсын БХЯ-наас “Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх, “Хааны эрэлд” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд Япон улсын цэргийн алба

цэргийн эмнэлгийн салбарт хэрэгжүүлэх, Хуурай замын цэргийн командлал хооронд харилцаа тогтоох, Японы талаас техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зэрэг цөөнгүй чиглэлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд санал нэгдсэн. Үүнд эрхэм Элчин сайд Кобаяши Хироюки таныг бүх талын дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм.

Харин Элчин сайд Кобаяши Хироюки эртний танил Монгол Улсад томилогдсондоо сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд өнгөрсөн хугацаанд хоёр орны харилцаа, тэр дундаа Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж ирсэн байна. Амжилттай хөгжиж ирсэн энэхүү цэргийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэхийн төлөө өөрийн зүгээс онцгой анхаарч ажиллана гэдгээ онцлолоо.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ...



Батлан хамгаалах яамны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн хурлыг Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж удирдаж явууллаа. Уг хуралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн гишүүд болон тус яамны харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын салбар зөвлөлүүдийн дарга, гишүүд оролцсон юм.

Энэхүү хурлаар Зэвсэгт хүчний Жанжин штабын “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн 2019 оны тайланг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат, ҮБХИС-иас хэрэгжүүлсэн ажлын тайланг ҮБХИС-ийн захирал, хурандаа П.Жаргалан, Батлан хамгаалах яамны харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлүүдийн 2019 оны үйл ажиллагааны тайланг БХЯ-ны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн, хурандаа Л.Баатар нар хэлэлцүүлсэн.

БХЯ-ны харьяа байгууллагуудын салбар зөвлөлөөс өнгөрсөн онд хэрэгжүүлсэн ажил, тухайн байгууллагад гарсан хэрэг, зөрчил, авсан арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг сонссоны дараа Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалах яамны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн дарга Т.Дуламдорж хуралд оролцогчдоод үүрэг, чиглэл өгсөн юм. Тэрээр Төрийн албаны тухай болон Батлан хамгаалахын багц хуулиуд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль, журам, заавар, тогтоол, тушаалууд, Цэргийн нийтлэг дүрмүүдийг сайтар судалж, түүний хэрэгжилтийг бүрэн хангах, гэмт хэрэг, сахилгын зөрчлийг таслан зогсоох, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-үүдээс зохион байгуулах ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах, цэргийн хэмжил зүй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд сахих, ажилтан бүр албан тушаалын тодорхойлолтод заасан ажил, үүргээ үлгэр жишээчээр биелүүлэн бүтээлчээр ажиллахыг онцлон анхаарууллаа.

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАР ӨМНИЙН ЦЭНХЭР ГОВЬД ЧУУЛАВ



Аймаг, нийслэл/дүүрэг/-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалтыг 1 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Нийслэл болон Өмнөговь аймагт зохион байгууллаа. Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд цугларалтыг нээж Цэргийн штабын дарга нарт үүрэг даалгавар өгч, 2019 онд ажил үйлсээрээ манлайлсан Нийслэл болон Баян-Өлгий, Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарт өргөмжлөл гардууллаа. Онолын

болон дадлагын гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдсэн цугларалт “Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангах нь” сэдвийн дор явагдлаа. Онолын хэсгээр цугларалтад оролцсон бүрэлдэхүүнд Дайчилгааны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон тус хуультай холбогдсон бусад заалт, дүрэм, журмуудын талаар холбогдох албаны хүмүүс мэдээлэл өгсөн.

Мөн Цэргийн штабуудад тулгамдаж байгаа нийтлэг асуудлууд болон өмнөх оны ололт

амжилт, цаашид үйл ажиллагаагаа төгөлдөржүүлэхэд юунд анхаарч ажиллах талаар харилцан ярилцсан юм.

Түүнчлэн 2019 онд нийслэлийн дүүргүүдээс үйл ажиллагаагаараа манлайлж, “Тэргүүний Цэргийн штаб”-аар шалгарсан Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын үйл ажиллагаатай цугларалтын бүрэлдэхүүн танилцлаа. Дадлагын хэсгээр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт онц байдал үүссэн тохиолдолд төрийн

захиргааны байгууллагууд хэрхэн зохион байгуулагдаж ажиллах талаар хэзэрийн нөхцөлд үзүүлэх сургуулийг хийсэн нь тус цугларалтын нэгэн онцлог байлаа. Энэ тухай БХЯ-ны СБТГ-ын дарга, бригадын генерал Г.Сайханбаяр хэлэхдээ “Энэ удаагийн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалт орон нутагт тэр дундаа Өмнөговь аймагт явагдсанаараа онцлог байлаа. Цугларалтаар Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хүрээнд тухайн

газар оронд дайчилгааг хэрхэн зохион байгуулах талаар үзүүлэх сургуулийг хийлээ. Энэхүү дадлага, сургуулийг зохион байгуулахад Өмнөговь аймгийн Засаг дарга, ЗДТГ, Цэргийн штаб, Даланзадгад сумын ЗДТГ-ын хамт олон маш их хичээл зүтгэл гарган ажиллажээ. Сургуульд Даланзадгад сумын найман багийн Засаг дарга нар, ЗДТГ-ын алба хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсонд тун баяртай байна” гэв.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАР ӨМНИЙН ЦЭНХЭР ГОВЬД ЧУУЛАВ

(Түрүүч нь | нүүрт)

ЦААШДАА Ч МӨН ОРОН НУТАГ ДАХЬ ЦЭРГИЙН ШТАБЫГ ТҮШИГЛЭН ЯВУУЛНА



БХЯ-ны СБТГ-ын хэлтсийн дарга, хурандаа С.ГАНБЯМБА:
-Аймаг, нийслэл, /дүүрэг/-

ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалтыг Батлан хамгаалах яам Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран орон нутагт хоёр дахь удаагаа зохион байгууллаа. 2018 онд Дайчилгааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан БХЯ-наас Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах журмуудад өөрчлөлт оруулсан. Цэргийн штабын дарга нар маань тэдгээр журам, заавруудыг орон нутагт хэрэгжүүлэх талаар санал солилцож, тодорхой заавар, зөвлөгөө авч, бие биеэсээ туршлага судалсан нь энэ удаагийн цугларалтын нэгэн үр дүн байлаа. Мөн Орон

нутгийн хамгаалалтын тухай хуулийн хүрээнд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төрийн захиргааны томилгоот бүрэлдэхүүнийг зарлан мэдээллээр цуглуулж, орон нутгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Даланзадгад сум нь Батлан хамгаалах товчоог байгуулахад шаардагдах материаллаг баазаа тун сайн бэхжүүлснийг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй. Дараа, дараагийн цугларалтыг ч мөн орон нутаг дахь Цэргийн штабыг түшиглэн явуулахаар төлөвлөж байна.



Батлан хамгаалах товчооны бүрэлдэхүүн үзүүлэх сургуулийн үеэр авран хамгаалах ажиллагаа явуулж байгаа нь

ТАЙВАН ЦАГТ САЙТАР ДАДЛАГАЖИХ НЬ ҮР ДҮНТЭЙ ЮМ

Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа С.БАТ-ЭРДЭНЭ:

-Тус Цэргийн штаб нь Өмнөговь аймгийн Цэргийн штабтай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг. Энэ удаад орон нутагт Батлан хамгаалах товчоог хэргийн нөхцөлд хэрхэн зохион байгуулж болох талаар Өмнөговь аймгийн Цэргийн штабаас туршлага судаллаа. Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газраас дайчилгааны үед хүн болон техникийг татан оролцуулах төлөвлөгөөт баримт бичгүүдийг маш сайн боловсруулсан байна. Сумдын дайчилгааны даалгавартай аж ахуй нэгжүүд зохион байгуулалтад орж, тайван цагт сайтар сурган дадлагажсан байх нь чухал юм. Цаашид энэ талын үйл ажиллагааг аймаг, орон нутагтаа зохион байгуулах талд анхаарч ажиллах болно.

Бидний хувьд аймагтаа хэд хэдэн бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлээд байна. Тухайлбал, Аугаа их Эх орны дайны ялалтын 30 жилийн ойд зориулан 1975 онд босгосон "Орос цэргийн алдар" хөшөөг сэргээн засварлаж, Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэгт зориулсан хурандаа Х.Аюушийн



нэрэмжит танкийн хөшөө, их буу зэргийг суурилуулж, залуу хойч үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд хувь нэмрээ орууллаа. Тус дурсгалын цогцолборт дугуйн зам, усан оргилуур, цэцэрлэгт хүрээлэн зэрэг багтаж байна. Цаашид тохижилтод нь анхаарч, бүтээн байгуулалтын багагүй ажлыг хийхээр төлөвлөсөн. Мөн тус аймагт хугацаат цэргийн алба хаагчдыг улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцуулах зорилгоор хүнд машин механизмын мэргэжлийн үнэмлэх олгох сургалт явагддаг бөгөөд Цэргийн штабын зүгээс сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ИРГЭД ДАЙЧИЛГААГААР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ УХАМСАРЛАДАГ БАЙХ НЬ ЧУХАЛ



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.АМАРЖАРГАЛ:

-Энэ удаагийн цугларалтыг Батлан хамгаалах яам Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсанд тун баяртай байна. Бид тус цугларалтын үр дүнг дээшлүүлж, онцлог байдлаар явуулах үүднээс Цэргийн штабын дарга нарыг Зэвсэгт хүчний 167 дугаар анги, өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлууллаа. Мөн Цэргийн штабуудын ажлынх нь үндсэн чиглэл болох дайчилгаа зохион байгуулалтыг тайван цагт газар оронд хэрхэн зохион байгуулах талаар үзүүлэх сургууль хийсэн. Тус сургуулийг явуулахад Даланзадгад сумын ЗДТГ-ын бие бүрэлдэхүүн идэвх, санаачилгатай ажиллаж, бидний үйл ажиллагааг дэмжсэн. Хамгийн гол нь иргэд аливаа онц байдал үүссэн үед дайчилгаагаар хүлээсэн үүргээ ухамсарладаг байх нь чухал. Тиймээс энэ төрлийн сургалт, дадлагыг байнгын давтамжтай явуулж, жигдрэлт, зохион байгуулалтыг сайтар тодотгож байх хэрэгтэй юм. Манай аймгийн сумдын ЗДТГ-ууд тухайн жилийнхээ сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөндөө дайчилгаа зохион байгуулахад шаардагдах тодорхой төсвийг суулгадаг нь сургалт явуулахад маш том давуу тал болдог. Мөн Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар нь Цэрэг-онцгой байдал хариуцсан орон тооны мэргэжилтэнтэй бөгөөд томилгоот бүрэлдэхүүнийг дэлгэн байрлуулахад шаардагдах төлөвлөгөө, баримт бичгүүдийг тухайн албан тушаалтан хариуцан ажилладаг.

ЦУГЛАРАЛТААР ОЛЖ АВСАН МЭДЛЭГ, ТУРШЛАГАА ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛНО

Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Л.МӨНХБАТ:

-Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хүүхэд, залууст эх оронч үзэл, хүмүүжил олгох, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд хийсэн үйл ажиллагаагаараа 2018, 2019 онд нийслэлийн "Тэргүүний Цэргийн штаб"-аар шалгарсандаа баяртай байна. Тус амжилтад хүрэхэд дан ганц Цэргийн штаб гэлтгүй Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэд, олон нийтийн оролцоо чухал байсныг онцлон хэлэх нь зүйтэй. Миний бие 2017 онд тус дүүрэгт томилогдсоноос хойш Цэргийн штабын бэлэн байдлыг дээшлүүлэх талаар онцгой анхаарч ажилласан. Мөн иргэддээ Батлан хамгаалах



үйлчилгээг ая тухтай, чирэгдэлгүй хиргэх үүднээс нэлээд ажил хийж, Цэргийн штабын өрөө, тасалгааг шинэчлэн тохижуулсан. Хүүхэд, залууст эх оронч үзэл, хүмүүжлийг олгох

ажлын хүрээнд Баянгол дүүргийн Засаг даргатай хамтран "Эх орон-36" хөтөлбөрийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн. Хөтөлбөрөөр сурагчдад жагсаалын үндсэн элементүүдийг эзэмшүүлэх, эх орны үнэ цэн, тусгаар тогтнолын талаар яриа, таниулга хийх зэрэг олон ажлыг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ удаагийн цугларалт бидэнд маш үр дүнтэй байлаа. Ялангуяа хөдөө орон нутаг дахь Цэргийн штабын үйл ажиллагаа хэрхэн явагддаг, орон нутгийн төрийн захиргааны болоод төрийн цэргийн, хууль сахиулах байгууллагуудтай хэрхэн уялдан ажилладаг тухайд их зүйл мэдэж авлаа. Цугларалтаар олж авсан мэдлэг, туршлагаа үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх болно.

СУРГАЛТЫН ТӨВ БАЙГУУЛАХ НЬ АЧ ХОЛБОГДОЛ ӨНДӨРТЭЙ

Булган аймгийн Цэргийн штабын дарга, хурандаа Х.ЗОЛЗАЯА:

-Манай аймгийн хувьд өнгөрсөн жил Чин ван М.Ханддорж, Ардын Хатанбаатар С.Магсаржавын мэндэлсний тэмдэглэлт ойн баярууд болсон. Тэдгээр баярын үйл ажиллагаатай уялдуулан аймгийн хүүхэд, залууст эх оронч үзэл, хүмүүжлийг олгох зорилгоор олон төрлийн ажлыг зохион байгуулсан. Мөн Булган аймгаас дайнд оролцсон ахмад дайчидтай иргэдийг уулзуулж, тэдний алдар гавьяаг тэмдэглэлээ. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалтаар бид цаашид үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хэд хэдэн дэвшилтэт шинэ санааг авлаа. Ялангуяа орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэхийн тулд материаллаг баазаа сайтар бүрдүүлэх ёстой гэдгийг

Өмнөговь аймгийн Даланзадгад сумынхан харууллаа. Манай аймагт Зэвсэгт хүчний 234 дүгээр анги байрладаг ч аймгийн төвөөс зайтай тул байнгын хамтын ажиллагаатай байхад хүндрэлтэй байдаг. Тиймээс бидэнд сургалтын төв байгуулах асуудал нэн чухал байгаа юм. Одоогоор Зэвсэгт хүчний 186 дугаар ангийг түшиглэн сургалтуудаа зохион байгуулж байна.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хувьд Батлан хамгаалах товчоог хэргийн нөхцөлд дэлгэж, бодит байдал дээр оногдуулан данслагдсан дайчилгааны даалгавартай хүн болон техникүүдийг хязгаарлагдмал нөхцөлөөр татан нийлүүлж, үйл ажиллагаагаа тасаг, нэгжүүдэд хуваарилан үзүүлсэн нь онцлог байлаа. Бодит цагийн байдалд, хэргийн нөхцөлд явагдсан тус сургалтад сумын төрийн



захиргааны байгууллагын албан хаагчдыг идэвхтэй оролцуулсан нь тус аймгийн Цэргийн штабын үйл ажиллагаа орон нутагтаа хэрхэн үр дүнтэй явагддагийг тод томруун харууллаа.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЦЭРЭГ-ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, ХҮМҮҮЖИЛ ОЛГОХ ТАНХИМ БАЙГУУЛСАН

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа М.ДЭЛГЭРСАЙХАН:



-Тус Цэргийн штабын хувьд өнгөрсөн он амжилт бүтээлээр дүүрэн өнгөрсөн нь аймаг, сумдын Засаг даргын Тамгын газруудын удирдлага, албан тушаалтнуудаас бидний ажлыг үргэлж дэмжиж байдагтай холбоотой. 2019 оны гол ажлаас нэрлэвэл, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулахад анхаарч, тооцоо судалгааг нарийн гаргах үүднээс хоёр удаа аймаг, сумдын төрийн захиргааны байгууллагын алба хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Бидний ажлыг Батлан хамгаалахын сайдын зүгээс "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг нэлээд чамбай хийсэн байна" гэж үнэлсэн. Манай Өвөрхангай аймгийн Арвайхээр сум нь таван ерөнхий боловсролын сургуультай бөгөөд одоогоор нэг сургуульд нь цэрэг-эх

оронч үзэл, хүмүүжлийг олгох танхимыг байгуулаад байна. Ингэснээр Арвайхээр сумын болоод аймгийн ахлах ангийн сурагчид тус танхимаар байнга үйлчлүүлдэг болсон. Энэ жил мөн нэг сургуульд нэмж байгуулахаар төлөвлөсөн. Цаашдаа хүн ам ихтэй Хархорин, Богд зэрэг томоохон сумдын сургуулиудад энэ ажлыг хэрэгжүүлнэ. Мөн "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн бүх ерөнхий боловсролын сургуулиудад Зэвсэгт хүчний 256 дугаар ангийг хамтарсан ажлын хэсэг гарч, эх орны бахархал, тусгаар тогтнолын үнэ цэнийг хөндсөн сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлж байна. Мөн аймгаас төрсөн БНМАУ-ын баатар Л.Аюушийн хөшөө болон түүний орчин тойрныг шинэчлэн засварласан. Бидний хувьд цаашид хэрэгжүүлэх гол ажлын нэг нь орон нутгийн хамгаалалтын сургалтын төвийг байгуулах явдал юм.

Өмнөговь аймгийн Цэргийн штаб нь аймгийн Засаг даргын Тамгын газар, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтайгаа нягт хамтран ажилладаг нь цугларалтаар харагдлаа. Ялангуяа цэргийн ангийн байрлалыг түшиглэн орон нутгийн хамгаалалтын сургалтын төв байгуулсан нь тун онцлог байна. Үүгээр ч зогсохгүй Цэргийн штаб нь бие дааж сургалтыг явуулах бүх материал хэрэгслээр хангагджээ.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

“УРЛАГИЙН МАРШ ТАКТИК”-Т ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУД ӨРСӨЛДӨНӨ

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга хамтран жил бүр уламжлал болгон Монгол түмний үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шаштир, утга зохиол, бичиг соёлын өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, үндэсний соёл урлагийг сурталчлан, Монголын үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор “Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр” тэмцээнийг зохион байгуулдаг. Энэ жилийн тэмцээнийг тов гараад удаагүй байгаа бөгөөд тэмцээний зохион байгуулалт, онцлогийн талаар ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, хошууч Р.ӨНӨРЖАРГАЛААС тодрууллаа.

18 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа “Цагаан сар-Монгол түмний уламжлалт баяр” тэмцээн энэ удаа ямар онцлогтойгоор явагдах бол ...

-XVII жарны “Хулгана жил”-ийн сар шинийн баярыг угтан 18 дахь удаагаа явагдах “Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр” тэмцээний удирдамж нь төрийн цэргийн анги, байгууллагуудад хэдийнээ хүрсэн бөгөөд энэ жилийн тэмцээнийг 2020 оны 2 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд хоёр үе шаттайгаар зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна. Батлан хамгаалахын сайдын 2019

юу? Энэ жил юун дээр илүү анхаарвал зохилтой бол ...

-Уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс ардын авьяастнуудыг илүү мэргэжлийн байлгах бодлогыг баримталж байна. Тиймээс ЦДБЭЧ-ын үндэсний урлагийн бүрэн хэмжээний тоглолтыг тэмцээний өмнө толилуулахаар бэлтгэсэн. Энэхүү тоглолтыг тэмцээнд оролцогчид үзсэнээр тайз засалт, бүтээлийн илэрхийлэл, оролт гаралт, жүжигчилсэн тоглолт, хувцаслалт, биеэ авч явах байдал гээд санаа авах боломжийг олгож байгаа юм.

Мөн “Ардын дууны хүүхнүүд” тэмцээнд оролцогчид

томилогдоно. Мөн Монголын нэрт ардын дуучид, Төрийн шагналт зохиолчдын төлөөлөл гээд 5-6 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг ажиллана.

Ямар тоглолт үзүүлэх бол гэсэн хүлээлт үүсгэдэг шилдэг баг манай Зэвсэгт хүчинд олон доо. Тэдгээрээс дурдвал ...

-Газрын цээжинд давхидаг хэдэн сайхан морьдоо хэлээч гэвэл уяач хүн шиг бахархал дүүрэн нэрлэх ангиуд маш олон байна. “Цагаан сар-Монгол түмний уламжлалт баяр” тэмцээнд харуулын цэргээс ангийн захирагч нь хүртэл оролцдог Зэвсэгт хүчний 032 дугаар анги байна. Тэд бол Т.Онон уяачийн уяа сойлго нь яг таарсан хүлгүүд шиг байдаг. Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн “Алтан хорол” баг байна. Давс, хужрыг нь яг таг тааруулж, чамбай бэлддэг багуудын нэг. Мөн Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн баг жилээс жилд улам чангарч байдаг. Зэвсэгт хүчний 015 дугаар анги бол хөгжөөн дэмжигчдээрээ алдартай. Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн мэндчилгээг



оны А/313 дугаар тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах байгууллагуудад хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дэд төлөвлөгөө”-ний хүрээнд энэхүү тэмцээн маань зохион байгуулагдахаар болсон бөгөөд ийнхүү бодлогын баримт бичигт тусгагдаж байгаа нь тус тэмцээний ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа юм. Дараагийн нэг онцлог нь тэмцээний цар хүрээг нэмэгдүүлэх, олонд илүү таниулах, төрийн цэргийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс энэ жилээс төрийн цэргийн байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын дунд зохион байгуулах гэж байна. Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас гадна Онцгой байдал, Дотоодын цэргийн алба хаагчид оролцохоор бэлтгэлээ хангаж эхэлсэн бөгөөд ойролцоогоор 30-аад баг өрсөлдөх магадлалтай байна.

Оролцогч байгууллагуудад хандаж мэдээлэл өгөхгүй

дуулалт дээр илүү анхаарах хэрэгтэй. Ардын дуу нь их олон бадагтай байдаг. Тухайлбал “Алгирмаа” л гэхэд дуулалт жүжгийн хэмжээний бүтээл. Тиймээс энэ дууны 3-4 бадгийг л зөв сайхан дуулах нь чухал. Түүнчлэн Үндэсний найрал хөгжимчидтэй бэлтгэлээ хийх боломжийг бүрдүүлэн өгч байгаа учир бэлтгэлийн цагаа урьдчилан тохирох хэрэгтэй. Бид өмнөх жилүүдэд асуулт хариултын төрөлд үндэсний бахархал болсон эртний уран зохиолуудаас сонгож байсан бол энэ удаад Монгол Улсын Төрийн шагнал хүртсэн зохиолуудаас сонголт хийлгэхээр удирдамжид тусгасан байгаа. Тиймээс зохиолоо унших явцдаа тухайн зохиолчийн намтар, ямар бүтээлээрээ хэдэн онд Төрийн шагнал хүртсэн, зохиолын онцлог зэргийг сайтар тогтоож унших хэрэгтэй гэж зөвлөө.

Шүүгчдийн бүрэлдэхүүний талаар ...

Мэдээж хамтран зохион байгуулагч Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын бүрэлдэхүүнээс шүүгчид

дурдалгүй өнгөрч болохгүй. Маш содон, шинэлэг байж шүүгч, үзэгчдийг алмайруулж чаддаг.

Тэрчлэн тодруулбал, Зэвсэгт хүчний 032 дугаар анги өгүүлэмж, дүрийн тоглолт руу их анхаардаг драмын үгшилтэй. Гэтэл Зэвсэгт хүчний 311 дүгээр анги үндэсний хөгжмийн бүтэн хамтлагтай бэлдэж орж ирдэг. Зэвсэгт хүчний 013 дугаар анги үндэсний хувцас, хэрэглэл маш сайтай. Харин Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн залуучууд мэргэжлийнхээ онцлогийг тайзтай сайхан холбож чаддаг гээд дурдаад байвал шилдэг ангиуд олон бий.

Төгсгөлд нь хэлэхэд, иргэн бүр Монголын соёлын бахархлыг тээгч болохоор улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёлын үнэт өвийг уламжлан хөгжүүлэх эрхэм зорилготой тэмцээндээ ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн сэтгэл зүрхээ нэгтгэн оролцохыг уриалж байна. Энэхүү тэмцээн нь та биднээр дамжуулан үр хүүхэд, гэр бүлдээ үндэсний уламжлалт өв соёлоо түгээж байгаа чухал хэлбэр юм шүү гэдгийг онцлон хэлмээр байна.

ХҮНДЭТ ХАРУУЛЫН АНГИД “НЭГ ӨДӨР” ...

“Төрийн бус байгууллагын нэг өдөр” гэх сонин содон нэртэй арга хэмжээ Зэвсэгт хүчний 032 дугаар ангид боллоо. “Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл” ТББ-аас өнгөрсөн онд “Дайны бурхан” их буучдын ангид ийм өдөрлөгийг зохион байгуулсан санаачилгаа үргэлжлүүлж энэ удаад “Төрийн хүндэт харуул”-ын хэмээн олон түмнээ алдаршсан ангийг сонгожээ.

хурандаа Б.Жуваа нар хүндэт зочдоодоо хүндэт харуулын нэр хүндтэй албанд томилогдсоныг батлах архивын лавлагаа, дурсгалын зүйлийг гардууллаа. Мөн Нэгдсэн эвлэлээс тус ангийн номын санд 30 гаруй ном, дөрвөн төрийн хэвлэлийг хандивлав.

Хүндэт харуулын 21 дэх дарга, бэлтгэл хурандаа Г.Булган Төрийн ёслол бүрийн өмнө хүндэт зочны намтар, тухайн орны түүх,



Энэ нь цаанаа бас учир начиртай. 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ой тохиож буй 2020 оны эхэнд сумангийн улс төрийн удирдагчаар энэ дайнд оролцсон хурандаа генерал Ж.Ёндонгийн нэрэмжит ангид ТББ-ынхан нэг өдөр саатаж, өнгөрсөн түүх, ахмад үеэ хүндэтгэн дурсаж, эзэмшсэн мэргэжил, мэдлэгээ сурталчлав. Улс төрийн ажилтнуудын дундаас цэргийн хэргийн мэдлэг, жагсаалч, жавхаалаг байдлаараа тодрон гарсан олон зүтгэлтний нэг нь “Рапорт” Ёндон байсныг Нэгдсэн эвлэлийн тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа өдөрлөгийг нээж хэлсэн үгэндээ онцлон дурдсан.

Эх орон, Зэвсэгт хүчний нэрийн хуудас болсон Хүндэт харуулын ротын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Г.Булган, хурандаа Б.Мандахгэрэл, улс төрийн орлогч асан, бэлтгэл дэд хурандаа Ц.Батбаяр, Б.Батхуяг, салааны захирагч асан, бэлтгэл ахлах дэслэгч Д.Есүхэйбаатар нар хүндэтгэлийн суудалд уригдав. Энэ жил Хүндэт харуулын рот үүсэн байгуулагдсаны 65 жилийн ой тохиож буй болохоор Нэгдсэн эвлэлээс тэдэнд онцгойлон хүндэтгэл үзүүлж байгаа ажээ. Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр, Нэгдсэн эвлэлийн тэргүүн, бэлтгэл

соёлын мэдээллийг ханын хэвлэл, ухуулга яриагаар бие бүрэлдэхүүнд хүргэдэг улс төр, соёл хүмүүжлийн ажилтнуудын зүтгэл, чармайлт чухал байсныг эргэн дурсав. Бэлтгэл дэд хурандаа Я.Эрдэнэ “Цэргийн алба нь тэсвэр хатуужил, мэдлэг, чадвар суулгадаг чухал хөдөлмөр” болохыг дурдаад, Төрийн хүндэт харуулд алба хааснаараа хүн бүр бахархах учиртайг сануулсан юм.

Доктор, профессор, бэлтгэл хурандаа Ж.Энхбаяр “Мэдлэгт суурилсан хөгжил, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зарим боломж” лекцээ толилууллаа. Хуучирч элэгддэггүй, хуршиж хөгцөрдөггүй, хур усанд нордоггүй, хулгай авдаггүй, хулгана иддэггүй-энэ бол эрдэм мэдлэг гэсэн Хөвд аймгийн нэгэн багшийн үгээс эхлээд Монголын урлаг, уран зохиолд дурдагдсан ишлэл ямар гүн утга, агуулгыг илэрхийлж байдгийг жишээ татан өгүүллээ.

Түүх, дурсамж, танин мэдэхүйн ертөнцөд аялуулж, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид ая дууны түрлэг өргөсөн, Алдрын танхим, Хүндэт харуулын ротын үйл ажиллагаатай танилцаж, Ж.Ёндонгийн нэрэмжит танхимыг ялалтын ойн өмнө шинэчлэх бүтээлч яриа өрнүүлсэн гээд баялаг агуулгатай өдөрлөг болж өндөрлөв.

Ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

ТАСГИЙН БУУДЛАГА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



Зэвсэгт хүчний 350 дугаар анги цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу тасгийн жигдрэлтийн шатны хээрийн гаралт, полигоны дадлага, тасгийн буудлагыг 119 дүгээр ангийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн явууллаа. Хээрийн сургалт, дадлагыг буудлага, тактик, цэргийн байр зүй, эмнэлэг, артиллери, хими зэрэг хичээлийн цэгүүд байгуулан төрөл бүрийн нормативыг боловсруулж явуулав. Энэ хүрээнд “Мотобуудлагын тасаг явдлаас давшилтад” сэдвээр

тасгийн байлдааны буудлагыг явуулахад ахлагч Х.Алтаншагай, ахлагч М.Мэндбаяр захирагчтай тасаг, ахлах ахлагч Ж.Буян, ахлах ахлагч Б.Баасансүрэн даргатай тоот “Онц” үнэлгээтэй буудлаа. Энэ үеэр бие бүрэлдэхүүнд мотобуудлагын ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн байлдааны буудлага, салааны байлдааны буудлага, тасгийн буудлагын бичлэгийг үзүүлэн гар барилдааны тэмцээнийг зохион байгуулсан юм.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИЖ

Редакцын шууданд

013 дугаар анги

“Бага Баян-Энхийн төлөө цогцолбор төв”-д “Цэвэр агаар-идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт цасны баярыг байнгын бие бүрэлдэхүүн болон тэдний гэр бүлийн хамт тэмдэглэн өнгөрүүлээ. Энэхүү баярын үеэр “АХА”, “Сумо”, “Гар бөмбөг”, “Олс таталт” гэсэн дөрвөн төрлөөр цогцолбор тэмцээнийг зохион байгуулахад хошууч М.Ундрам даргатай баг нэгдүгээр байр, хошууч Ө.Баярбадрах даргатай хамт олон хоёрдугаар байрт тус тус шалгарлаа. Энэ удаагийн цасны баярт байнгын бие бүрэлдэхүүний гэр бүлийг урьж, тэмцээн уралдаануудад тэдний төлөөллийг оролцуулан, ангийн үйл ажиллагааг сурталчлан таниулснаараа онцлог байлаа.

Ахмад З.АНХБАЯР

“АЛДАР”-ЫНХНЫ АМЖИЛТЫН БУУХИА ҮРГЭЛЖИЛСЭЭР ...



Турк улсын Истанбул хотод зохион байгуулагдсан 33 дахь удаагийн “Ahmet Comert”-ийн нэрэмжит олон улсын тэмцээнд Батлан хамгаалах яамны харьяа “Алдар” спорт хорооны тамирчин, ОУХМ Х.Энхмандах 52 килограммын жинд алт, ОУХМ Х.Энх-Амар 57 килограммын жинд алт, ОУХМ

Б.Чинзориг 64 килограммын жинд хүрэл медалийг тус тус хүртжээ. Түүнчлэн БНХАУ-ын Тяньжин хотноо “Binhai chess open” олон улсын нээлттэй тэмцээн болж дүнгээ гаргалаа. Уг тэмцээнд 97 тамирчин оролцсон бөгөөд “Алдар” спорт хорооны тамирчин, шатрын их мастер, ахмад Б.Мөнгөнтуул

эмэгтэйчүүдээс нэгдүгээр байр, шатрын их мастер, ахлах ахлагч Ц.Батчулуун шагналт тавдугаар байрыг тус тус эзэллээ.

Мөн Монголын байт харвааны холбооны 2020 оны эхний тэмцээн болох “Улирлын нээлт”-ийн тэмцээнд “Алдар” спорт хорооны тамирчид амжилттай оролцлоо. Тэмцээнд найман байгууллагын 70 гаруй тамирчин өрсөлдсөнөөс эрэгтэй хувийн харваанд М.Энхбаяр алт, Б.Тэнгисболд мөнгөн медаль хүртэж, Б.Отгонболд дөрөвдүгээр байр эзэлсэн бол эмэгтэй ганцаарчилсан харваанд Н.Ариунбилэг мөнгөн медаль хүртжээ. Эрэгтэй, эмэгтэй багийн төрөлд багаараа алт, холимог багийн харваанд Б.Тэнгисболд, Н.Ариунбилэг нар мөнгө, өсвөрийн хөвгүүдийн харваанд Т.Билгүүн алт, компаундын төрөлд Л.Алдар алтан медаль хүртсэн бөгөөд байгууллагын дүнгээр “Алдар” спорт хорооны баг тамирчид таван алт, гурван мөнгөн медальтайгаар хоёрдугаар байрт шалгарлаа.

ӨМНӨД СУДАНААС МЭДЭЭЛЖ БАЙНА

МОНГОЛЧУУД, “MONBATT”-ЫН НЭР ХҮНД ӨНДӨР

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөн хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

“MONBATT-IX” хэмээх энэхүү нэрээр овоглогдон нэгэн хамт олон болж төлөвшсөн цэнхэр дуулгат дайчдын маань сэтгэлээс ундарч, гараар бүтээгдсэн, хөлс хүч шингэсэн олон ажил энд биеллээ олж, үйлс зорилго нэгт олон орны дайчдын тэргүүн эгнээнд манлайлж явна. Цаг агаар, цагийн байдлын ямар ч

нөхцөлд богино хугацаанд дасан зохицож, НҮБ-ын өмнө хүлээсэн үндсэн үүргээ алдаа мадаагүй, нэр төртэй биелүүлэхийг эрхэм болгон шамдаж буй IX ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнийхээ энэ сард хийсэн томоохон ажил, онцлох үүрэг гүйцэтгэлтийн талаар уншигч Та бүхэнтэй хуваалцъя.

30 ГАРУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ САР ГАРУЙН ХУГАЦААНД ...

Батальоны захирагчийн тушаалаар өнгөрсөн 12 дугаар сарын 16-ны өдрөөс энэ сарын 19-ний өдрүүдэд ахмад Ч.Сэр-Одоор ахлуулсан 30 гаруй цэргийн алба хаагч, таван нэгж техниктэйгээр

нөхдөөсөө өндөр үнэлгээтэй ирснийг энд онцолж байна.

Ахмад Ч.Сэр-Одоос үүрэг гүйцэтгэлтийнх нь тухайд тодруулахад “Бид баазын харуул хамгаалалтын тасаг, замын

ихэвчлэн зэвсэгтэй явдаг тухай ч нэмж өгүүлээ. Эдгээр нь үүрэг гүйцэтгэхэд хүндрэл учруулж байсан нь гарцаагүй ч тэр бээр дөвийлгөн ярьсангүй. Эндээс цэргийнхний тэсвэр хатуужил, зарчимч чанарыг, өөрөөр хэлбэл удирдлагаас үүрэг даалгаврыг чанартай биелүүлж, итгэлийг зүтгэлээр хариулах нь чухал болохоос урьтаж шалтаг тоочин, ухарч алхах нь сонин биш гэдгийг бэлхнээ харж болох юм.

Ахмад Ч.Сэр-Од цааш нь өгүүлэхдээ “Хэдийгээр бид сар гаруйн хугацаанд бие даан үүрэг гүйцэтгэсэн ч батальоны болон ротын удирдлагаас байнга заавар, зөвлөгөө өгч, зааж чиглүүлж, тусалж дэмжиж байсанд талархаж байна” хэмээлээ. Мөн хамтран үүрэг гүйцэтгэсэн дэмжлэгийн салбаруудын цэргийн алба хаагчдадаа ч баярласнаа илэрхийлсэн юм.

Тэр бээр “Монгол цэргийн нэр хүнд хаана ч өндөр байдаг бахархаж явлаа. Зөрг өнгөрсөн орон нутгийн иргэн бүр, хамтран үүрэг гүйцэтгэсэн Энэтхэг улсын цэргийн алба хаагч болгон бидэнд баярлалаа гэдэг үгийг харамгүй хэлж байсан. Ялангуяа Энэтхэгийн инженерийн ротын цэргийн алба хаагчид монгол цэргүүдийн хамгаалалтад ямар ч хүндрэл бэрхшээлгүй, айх аюулгүйгээр үүрэг амжилттай гүйцэтгэлээ гэдгийг онцолсон” хэмээн ярианыхаа төгсгөлд тодотгов.

“БАР ЭЛ ГАЗАЛ” ГОЛД УСНЫ ЭРГҮҮЛИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭВ



Хүчний командлагчийн тушаал, Юнити секторын командлагчийн захирамжийн дагуу энэ сарын 2-6-ны өдрүүдэд батальоны хариуцлагын бүс дэх “Мунга” суурин буюу “Хубилай” баазаас 60 километр зайд урсдаг “Бар Эл Газал” голд батальоны захирагчаар ахлуулсан усны эрүүлийн бүлэг үүрэг гүйцэтгэв. Тэд зөвхөн усны эрүүл хийгээд зогсохгүй явган болон автомашинтай эрүүлийн үүргийг ч давхар гүйцэтгэсэн юм. Тухайлбал, “Мунга”, “Чонгриах”, “Някиер”, “Батхуах” зэрэг сууринд өдөрт 20 километр замыг туулан явган, “Курбона-1”, “Курбона-2”, “Мунга” сууринд өдөрт 25-30

километр автомашинтай эргүүл хийж, орон нутгийн иргэдтэй уулзан, амьдрах нөхцөл, аюулгүй байдал болон тулгамдаж буй асуудлуудынх нь талаар ярилцсан юм. Эдгээр сууринд Өмнөд Суданы Ардын Батлан Хамгаалах Хүчний I дивизийн X бригадын гурван салаа байрлан үүрэг гүйцэтгэж байсан төдийгүй дээрх суурингуудын удирдлага, Юнити мужийн Засаг даргын аюулгүй байдлын зөвлөх, X бригадын захирагч, мужийн үндэсний аюулгүй байдлын албаны дарга болон цэргийн хүчний төлөөлөлтэй батальоны захирагч уулзаж цагийн байдлын талаар мэдээлэл солилцов.



“Хөтөл” баазад үүрэг гүйцэтгээд ирлээ. Тодруулбал, тэд Бентью хотоос Лийр суурингийн чиглэлийн 90 километр замыг засварласан Энэтхэг улсын инженерийн ротын замын хамгаалалтын үүргийг гүйцэтгэсэн юм. Баазынхаа харуул хамгаалалтыг зохион байгуулах, Энэтхэгийн цэргийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, зам засварын үед орон нутгийн иргэдийн хөдөлгөөнийг хянах зэргээр олон ажлыг давхар нугалж, орон нутгийн иргэд болоод хамтран ажилласан энэтхэг

хамгаалалтын тасаг, бэлэн байдлын тасаг гэсэн зохион байгуулалтаар үүргээ гүйцэтгэсэн. Зам засварын ажилтай уялдаж “Хубилай” баазаас 20, дараа нь 40, сүүлд нь 66 километр гурван удаа шилжин байрласан” хэмээн тодотголоо. Мөн цаг агаарын хувьд өдөртөө хэт халуун, хорхой шавж, зөгий, могойноос гадна цөөвөр чоно, ирвэс зэрэг зарим төрлийн араатан амьтан элбэг, дээр нь орон нутгийн бага насны хүүхдүүд хоол хүнс гуйж ирдэг, өсвөр насныхан

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ 340 ШАХАМ ИРГЭНД ҮЗҮҮЛЛЭЭ

Мотобуудлагын батальоны хариуцлагын бүс дэх “Курбона” болон “Мунга” сууринд (Хубилай баазаас 60 гаруй километр байрладаг) энэ сарын 16, 17-ны өдрүүдэд иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд хүмүүнлэгийн ажиллагааг зохион байгууллаа. НҮБ-аас явуулж буй үйл ажиллагаа, энхийг сахиулагчдын, тэр тусмаа монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэлтийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролд бага ч атугай хөрөнгө оруулалт хийх, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийж, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэхэд энэ удаагийн ажлын гол зорилго чиглэгдсэн юм. Эхний өдөр буюу 16-ны өдөр дээрх суурингуудад нийтийн бие засах газрыг шинээр

барих ажил, дараагийн өдөр иргэдэд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх ажил өрнөв.

Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээг хүлээн авах, бүртгэлийн хэсэг, зүрхний цахилгаан бичлэг, дотор-1 /зүрх судас, уушги, хүүхдийн үзлэг/,

дотор-2 /хоол боловсруулах, бөөр, шээсний зам, хүүхдийн үзлэг/, мэс засал, гэмтлийн эмчийн үзлэг, мэс ажилбар, боолт, чих, хамар, хоолой, мэдрэлийн эмчийн үзлэг, хэт авианы шинжилгээ, эм тараах, орчны халдваргүйтгэл, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт гэсэн чиглэлүүдээр явуулсан юм. Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд хоёр суурингаас нийт 340 шахам иргэн хамрагдсан бөгөөд тэдний дийлэнх нь хоол боловсруулах замын болон зүрх судасны эмгэгтэйг эмч, мэргэжилтнүүд хэлж байлаа.

Дашрамд, дээр өгүүлсэн усны эрүүлийг хийх хугацаанд эдгээр сууринд бие засах газар байхгүй, гэр болон голынхоо ойр орчимд бие засаж, голоосоо

ундны усаа зөөдөг зэргээс үүдэн тус суурингуудад иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажил явуулах зайлшгүй шаардлага урган гарсныг ийнхүү бодит ажил болгосныг онцлох нь зүйтэй биз ээ.

Ийнхүү иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд дээрх хоёр сууринд өрнүүлсэн эмнэлэг хүмүүнлэгийн ажиллагаа амжилттай явагдаж, иргэдийн талархлыг хүлээсэн чухал ажил боллоо. Одоо тус батальоны бие бүрэлдэхүүн НҮБ-аас улирал тутамд явагддаг “CEO” буюу цэрэг, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмжийн нөхөн төлбөр баталгаажуулах шалгалтад бэлтгэж засвар үйлчилгээ, тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудад шамдаж байна. Тус шалгалт ирэх сарын 4, 5-ны өдрүүдэд явагдах юм.



Орон нутгийн иргэдийн зарим төлөөлөлтэй уулзаж сэтгэгдлийг нь сонссоноо хүргэе.

“MONBATT”-Д БИД ИТГЭДЭГ



Бидний эх хэлээр торохгүй ярих энэ хүүг Жеймс гэдэг. Тэрээр “Миний монгол нэр Буяка” хэмээн өөрийгөө танилцуулсан бөгөөд “MONBATT-8”-ынхнаас монгол хэл сурсан, тэр ээлжинд миний олон найз байсан. Монгол цэргүүд хамгийн шилдэг нь. Тэдний ачаар Дотоодын дүрвэгсдийн хуаранд айх аюулгүй, тайван амьдарч болно, “MONBATT”-д бид итгэдэг” гэх мэт магтаалын үгсийг урсгаж байв. Жеймс буюу Буяка 14 настай, долоодугаар ангид сайн дүнтэй суралцдаг аж. Тэдний хамгийн олон буюу 118 мянга шахам иргэнтэй Дотоодын дүрвэгсдийн хуаранд амьдарч байгаад өнгөрөгч 11 дүгээр сард Курбино суурин руу шилжжээ.

ХАМГИЙН ШИЛДЭГ НЬ МОНГОЛ ЦЭРГҮҮД

АНЖЕЛИНА:
-Миний сэтгэл маш өндөр байна. Яагаад гэвэл монгол цэргүүд сэтгэл гаргаж бидний сайн сайхны төлөө их зүйлийг хийж байна шүү дээ. Би хамгийн шилдэг энхийг сахиулагчид, хамгийн энэрэнгүй үйлстнүүд бол монгол цэргүүд гэдгийг сайн мэднэ. Өнөөдөр дахиад л батлан харуулж байна. Бидэнд эмнэлгийн үйлчилгээ авах боломж хомс, манай Курбино суурингийн

ойролцоо эрүүл мэндийн ямар нэгэн байгууллага, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг газар байдаггүй. Тиймээс өвдсөн тохиолдолд бид хол замыг туулан Бентью хот руу явах шаардлага гардаг, гэтэл машин байхгүй гэх мэт хүндрэлүүдтэй тулгардаг. Харин өнөөдөр монгол цэргүүд, монгол эмч нар биднийг зорин ирж эмнэлгийн үзлэг, оношилгоо хийж, хэрэгцээтэй эм өгсөнд туйлын баяртай байна.



ОЙР ОЙРХОН ИЙМ АЖИЛ ӨРНҮҮЛЭЭСЭЙ

ШИРМЕРИ:
-Би энэ суурингийн захиргааны ажилтан. Монгол цэргүүд манай сууринд хүрэлцэн ирж, иргэдэд үзлэг, оношилгоо хийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байгаад маш их баяртай байна. Бентью хот орохоос өөрөөр ойрхон эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг газар энд байдаггүй. Тийм учраас монгол цэргүүдийн үзүүлж байгаа энэхүү эмнэлгийн тусламж ёстой л нүдээ олсон ажил боллоо. Зөвхөн эмнэлгийн үзлэг, оношилгооноос гадна бие засах газрыг барьж, орчны ариутгал хийлээ. Мөн иргэдэд эрүүл мэндийн сургалтыг явууллаа. “MONBATT”-ын удирдлага, сэтгэл гарган ажилласан монгол цэргүүдэд баярлалаа. Эцэст нь ийм ажлыг ойр ойрхон зохион байгуулж байгаасай гэж хүсэж байна.



УДАХГҮЙ ЭДГЭЖ ЭРҮҮЛ БОЛНО



ВЛЮМДЕНЬ:

-Монгол цэргүүдэд баярлалаа гэж хэлье. Миний бие өвдөөд хэдэн өдөр өнгөрсөн ч Бентью хот руу явж амжихгүй байлаа. Гэвч өнөөдөр монгол цэргүүд ирж бидэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэнд туйлын баяртай байна. Эмч нар ходоод маань өвдсөнийг хэлж, эм өгсөн. Тиймээс монгол эмч нарын ачаар миний бие удахгүй эдгэнэ гэдэгт итгэж байна.

Нүүрийг бэлтгэсэн ахмад Д.МЭНДБАЯР

Н.Цэрэндорж: ХОШУУЧ ГЕНЕРАЛ Р.ГАВАА МИНИЙ ХИЧЭЭЛД СУУДАГ БАЙЛАА

Манай уншигчдад өөрийгөө товч танилцуулахгүй юу?

-Би Говь-Алтай аймгийн уугуул. Гуч гаруй жил математикийн багшаар ажилласан. Хань минь хүүхдийн эмч мэргэжилтэй, гурван сайхан хүүхэд төрүүлж өсгөсөн, зургаан ач, зээтэй. Одоо тэд маань мэргэжлээрээ ажиллаж байна.

Ярилцлага эхлэхийн өмнө та надад багаасаа их зовлон үзсэн гэж хэлсэн. Та сэтгэл дотроо юу тээж явдаг юм бол гэсэн бодол төрлөө ...

-Тэртээ намар ихий минь эрт босоод хонины хотондоо ортол хоёр хуц мөргөлдөж байгаад эвэр нь угалзаараа мушгирагдаад салахын аргагүй юм болсон байж. Салгах гэж ээж нүцгэн гараараа л үзэж тарсан юм билээ. Гэтэл гарын алга руу нь нэг хуцны нь эврээс ёрдойж гарсан том өргөс шигдчихсэн гэнэ лээ. Хүн ч мэдэхгүй өөрөө ч тоохгүй явсаар өвөл өвдөж, хавар хавдаад намайг гурван ой хүрэхээс өмнөхөн бурхан болсон доо. Рэнцэн гэж хүн байсан л гэдэг, овгийг нь сайн мэдэхгүй. Би юмны учир ойлгохтойгоо болоогүй байх үед ээж тэнгэрт хальсан учраас тийм ийм дурсамж бий гээд нэг их сайхан гэгээлэг зүйлсийн талаар ярьж чадахгүй нь дээ. Би уг нь зургаан хүүхэдтэй айлын хамгийн бага нь ухаантай юм. Манай аав Д.Ням гэж хүн байлаа. Жирийн л нэг малчин байсан. Эгч, дүүс бидний ээжийн араас унагасан нулимс бараг хатаагүй шахам байхад ахтай минь уулзана гээд хот бараадсан. Тэндээ намаржаад өвөлжчихсэн шүү. Төд удалгүй 1957 онд өөд болсон. Ер нь багадаа ийм их хагацал үзэх хэцүү ч жаргал, зовлонгийн аль алийг нь ялгалгүй дааж чаддаг сэтгэлийн хаттай болдог юм билээ. Зундаа ахынхаа малыг хариулж, намар ноосыг нь тушаагаад хичээлийн хэрэглэл, хувцсаа бэлддэг, ганц "бакаал" гуталтай жилийн дөрвөн улирлыг барна гээд ёстой урд хормойгоороо хойдхоо нөхдөг байлаа.

Багш хэмээх алдрыг анх хэзээ хүртсэн тухайгаа хуучлахгүй юу?

-Би 1963 онд 10 дугаар анги төгссөн. Тэр үед одоогийнх шиг элсэлтийн шалгалт өгдөггүй, хүүхэд бүр л их, дээд сургуульд хуваарилагддаг байв. Надад ОХУ-д суралцах боломж олдсон ч их мөнгө зардал болох байх даа гэж халаглаад Монголдоо үлдсэн юм. Тэр нь ч нүдээ олон. Сургуульдгүй хоцорсон би азтай тохиолдлоор бага ангийн багш болдог юм байна. Тухайн үеийн аймгийн Боловсролын хэлтсийн дарга өөрөө надад бага ангийн багш болох санал тавьж, "Цөөн хэдэн жил л ажиллачихвал хүссэн сургуулийн чинь хуваарийг өгье" гээд намайг сэнхрүүлчихлээ шүү. Тэр даргын үгэнд итгээд Говь-Алтай аймгийн төвд ЕБС-д нэг жил ажилласан. Эр эмгүй, хөгшин залуугүй гар хөлийн үзүүртээ зарчихдаг, ер нь надаа л их "баавар" хүмүүс байж билээ. Ингэж нэг жил болсны эцэст намайг ятагдаг өнөөх Боловсролын хэлтсийн даргатай улзахаар очтол, оронд нь өөр хүнийг томилсон байж таарлаа. Гэсэн хэдий ч шинэ даргад сургуулийн хуваарь, энэ тэр гээд тохиролцооны талаар цухуйлгалгүй төрж, өссөн газраа очиж ажилламаар байна гэдэг хүсэлтээ уламжлаад санасандаа хүрч Дарви сумыг зорилоо. Эхний жилдээ дөрөвдүгээр анги дааж аваад ажиллаж байтал аймгийн Боловсролын хэлтсээс хоёр багш манай сургуульд шалгалтаар ирэх нь тэр. "Шинэ халаадаа өмсөөрэй, ширээний бүтээлгээ солиорой" гэдэг шиг нөгөө сургалтын төлөвлөгөө, хичээлийн конспектоо даруй бэлдээд байж байтал огтоос тоож үзсэнгүй. Харин бага ангийн хүүхдүүдээс математик, монгол хэлээр шалгалт авлаа шүү. Тэр шалгалтад манай ангийн хүүхдүүд онц, сайн дүн авцгаасан. Тэгээд тэр дүнгээ миний улирлын төгсгөлд авсан шалгалтын дүнтэй харьцуулахад нэг их зөрүү байсангүй. Сурагчдаа зөв, бодитой үнэлсэн гээд их сайшааж магтсан. 1965 онд Сайд нарын зөвлөлөөс "Багш нарын баярыг тэмдэглэх тухай" тогтоол гарсантай холбогдуулан сумдын багш нарын мэргэжил, ур чадварыг нь харгалзаж үзээд баярт оролцуулахаар болсон юм

Эрдэм хэмээх оюуны капиталыг үнэгүй өгдөг мэргэжил бол гагцхүү багшийн мэргэжил. Бас багштай учралгүйгээр хүн төлөвшдөггүй гэдэг ч үнэн. Тийм дээ ч

**Ерийн малчны хотноос
Ертөнцийн дэвжээнд гаргасан
Ерхөг найгасан талаас
Есөн гарагт хүргэсэн**

**Багш та хүүхэд шуугисан их өргөөний эзэн юм
Багш та хүсэл долгилсон ирээдүйн замын эх юм** гэж шүлэглэсэн нь ч бий. Ингээд энэ цаг дор ахмад багш Н.Цэрэндоржтой хөөрөлдсөнөө уншигч танаа болгооё.



билээ. Нэгэнт шалгуур үзүүлэлт хангасан учраас аймгийн төв орж Монголын багш нарын анхны баярт оролцлоо доо. Говь-Алтай аймгийн бүх сумын багш нараас хоёр багш шалгарсны нэг нь би байсан юм.

Тухайн үед сайн багш, боловсон хүчнүүдээ шууд төв газар бараадуулчихдаггүй, өөр өөр газар руу томилж буурь сэлгүүлдэг байсан гэдэг. Тиймэрхүү бодлогын шинж чанартай зүйлс нь хэр үр дүнтэй байсан бэ?

-Хөдөлмөрийн гараагаа амжилттай эхлүүлсэн намайг ангиа төгсгөсний дараагаар Шарга сумын сургуульд томиллоо. Сурагчид нь сурлагын дүн тааруу, хоцрогдолтой байсан учраас ажлаа хаанаас эхлүүлэхээ сайн мэдэж байлаа. Хүүхдүүдтэй их ч тулж ажилласан, үр дүнд нь сурлагын чанар мэдэгдэхүйц дээшилж ирсэн юм. Би ч үүндээ их урамшсан, ажилдаа эзэн нь л болж байвал өөр хүсэх зүйл алга гэж бодож байтал их сургуульд суралцуулах талд анхаарна гэсэн том даргын үр санаанд орох нь тэр. Одоо тэр дарга байхгүй ч гэсэн бүтэж юуны магад гээд Боловсролын хэлтэст их сургуульд суралцуулж өгөхийг хүссэн өргөдөл бичээд явуулчихлаа. Горьдлого тээхээс өөр зүйл хийж чадалгүй хэд хонолоо. Нэг бүгчим, халуун өдөр сургуулийн дээвэр будаад алаг эрээн болсон юм сууж байтал аймгийн Боловсролын хэлтсээс намайг яаралтай дуудуулсан гэдэг мэдээг захирал дуулгалаа. Гадаа аагим халуун ч дотор сэрүүцээд, уужраад явчих шиг болсон. Гэхдээ асуудал ингээд амархан шийдэгдээгүй, Боловсролын хэлтэст МУИС-ийн математикийн багшийн ганцхан хуваарь ирсэн. Бүрэн дунд боловсролтой, ажил эрхэлж буй иргэдэд зориулж гаргасан хуваарь юм гэнэ. Би ч яаравчилж хот руу онгоцоор нисэж, очсон даруйдаа МУИС-д бүртгүүлээд шалгалтад орохоор боллоо. Их азтай тохиолоор тэрхүү шалгалтыг амжилттай давсан. Математик, физикийн шалгалтад авах ёстой 10 оноогоо авсан. Монгол хэл, уран зохиолын шалгалт бага зэрэг толгой гашилгасан. Яаж бэлдэхээ мэдэхгүй байсаар шалгалтын өмнөх өдөр Ц.Дамдинсүрэнгийн "Монголын шилдэг өгүүлэгчүүд"-ээс "Хэлдэг гурав, хийдэг ганц", "Хоёр цагаан юм" зэрэг дөрвөн өгүүлэг л уншлаа. Сайн бэлдээгүйн дээр мордохын хэзэйд гэгчээр өглөө гарахдаа шалгалтын хуудсаа номны завсар хавчуулаад мартчихаж. Ямартай ч гуйж гувшсаар нэг юм орж санаа амрав. Асуултаа сугалтал өнөөх урьд шөнө нь уншсан хэдэн өгүүлэгчүүдээс

ороод ирэх нь тэр. Баярласан гэж жигтэйхэн. Ёстой л аз нь шовойсон өдөр байсан. Шалгалтуудын нийлбэр дүнг танилцуулахад би 15-аас 14 оноо авснаар тэргүүлж МУИС-ийн математикийн багшийн ангид элсэн суралцах боломжтой болсон юм. Тухайн үед элсэлтийн комиссынхоос нэг нь миний аль аймгийнх, шалгалт авсан багш нарыг таньдаг, эсэх гээд далд угтгатай үгийг шидэж л байсан. Ашиг сонирхлын зөрчилтэй хүн гэж намайг хардсан ч байж болох. Гэхдээ би хэнийг нь ч танихгүй шүү дээ. Бор зүрхээрээ л явсан.

Боловсон хүчнээ бэлдээд авсан учраас аймаг, орон нутагтаа ирж ажиллах тухай санал тавьсан байх. Айдгаа авдартаа хийчихсэн шүү дээ ...

-Сургуулиа онц дүнтэй, улаан дипломтой төгссөн гээд хөдөө, орон нутаг руу явуулсангүй. Шинжлэх ухааны академийн Математикийн хүрээлэнд эрдэмтэн судлаачаар хуваарилсан. 11 дүгээр сараас ажилдаа ороорой гэсэн үүрэг, чиглэл өгтөл, Говь-Алтай аймгийн Боловсролын хэлтсийн дарга намайг авахаар хотод ирсэн байж билээ. Би ч уулзаад хаана хуваарилагдсанаа хэлэхэд Шинжлэх ухааны академид очиж удирдлагуудтай нь уулзана гэж хэлээд явсан. Ямартаа ч тэр дарга ялж, намайг аймаг, орон нутаг руу шилжүүлэх талаар их хөөцөлдөж санасандаа хүрсэн. Гэхдээ Шинжлэх ухааны академийн удирдлагууд ямар ч үед манай хаалга чамд нээлттэй гэж хэлсэн нь санаанаас гардаггүй юм.

Нутагтаа ирээд Анагаах ухааны техникумд хуваарилагдаад их ажлын уулзварт ирсэн гэдгээ мэдсэн. Долоодугаар ангиа төгсөөд орж ирсэн том залуусыг ширээний ард цавуудсан юм шиг суулгах даалгавар ноогдлоо. Эхний хагас жилийн дүнгээр аймагтаа нэлээд дээгүүр эрэмбэлэгдэж овоо дориун санагдлаа. Энэ үед "Соёлч нөхөрлөлийн анги" болох зорилт тавиад сурагчдаа танилцууллаа. Тэдний галтай цогтой нүднээс зорьсондоо хүрнэ гэсэн итгэл мэдрэгдэх шиг болсон. Энэ олон хүн зөвхөн надад итгэж байхад би ч бас эрвийх дэргийхээрээ зүтгэх ёстой юм байна гэдгийг ойлгосон. Тэр жилдээ анх удаагаа техникумын анги "Соёлч нөхөрлөлийн анги" болж чадсан. Дараагийн анги ч бас тийм амжилтыг үзүүлсэн. Сурлагын чанар, урлаг, спортын амжилтаараа ч улсдаа бусад техникумыг хол хаядаг боллоо. Би ч Боловсролын хэлтсийнхний нүдэнд өртөж жил бүрийн элсэлтийн шалгалтын комисст багтаж, бусад сумдад ажилладаг боллоо. Тэгж байтал аймгийн Боловсролын

хэлтсийн дарга Дашцэдэн намайг Цэргийн нэгдсэн дээд сургууль буюу одоогийн ҮБХИС-д математикийн багшаар ажиллах болсныг хэллээ. Тэр үед эхнэр маань АШУДС-д суралцахаар хот руу явчихсан байсан учраас би ч төвөггүйхэн зөвшөөрсөн. 1981 онд юм уу даа. Тухайн үеийн Цэргийн нэгдсэн дээд сургуульд ажиллана гэдэг амаргүй даваа байлаа. Сонсогчдын сурлагын чанар тун тааруу. Өглөөний 06.00 цагт гүйж ирээд цайндаа орсных нь дараа шууд хичээлд нь суулгачихна. Тийм ачаалал авсан хүүхдүүд хичээл дээр унтаад өгнө. Энэ үеэс эхлээд элсэлтэн дээр нь анхаарах хэрэгтэй гэж бодсон ч юу хийх ёстойгоо олж ядсаар байв. Ингээд 1983 он хүртэл хоёр жил гаруй хугацаанд судалгаа хийж автын болон холбоо, артиллер, танкийн ангиудад элссэн сонсогчдын материалтай танилцсан. Эцэст нь оны төгсгөлд хурал дээр "Сургалтын чанарыг дээшлүүлэх нь" гэсэн илтгэлээ тавьж хэлэлцүүлжээ. Сургалтын албаны дарга ч магтаад сүйд.

Өнөөх элсэлтийн чанарыг сайжруулах гээд арга олж ядсан үе тань ингээд дууссан байх нь ...

-Яг энэ үеэс арга олсон байхгүй юу. Би гэдэг хүн сургуулийн түүхэнд урьд хожид байгаагүй юм олж сэдсэн л дээ. ҮБХИС-ийн харьяа лицей сургуультай больё гэсэн бодол төрсөн хэрэг. ЕБС-иас нь тулгуур хичээлүүдийг нь сайтар судлуулаад гологдохооргүй сонсогчдыг бэлдчихвэл надад биш өөрсдөд нь хэрэгтэй шүү дээ. Сургалтын албанаас зөвшөөрсөн ч Ардын Армийн Улс төрийн газарт заавал дуулгадаг, зөвшөөрөл авдаг хүнд үед элдвийн зүйл

Тэр үед хошууч генерал Р.Гаваа хурандаа цолтой, сургуулийн захирал байсан. Нэг удаа энэ ер нь юу заадаг нөхөр вэ гэж сонирчихаад миний заадаг

магадлалын онолын хичээлд суусан юм. Ангийн хамгийн арын суудлаас хичээлд оролцоно. Би ч биеэ барьж эвгүйрхэх зүйлгүйгээр тэр хүнийг байхгүй юм шиг л хичээлээ заана. Голдуу самбартайгаа, сурагчидтайгаа харьцаад босоогоороо л өнждөг байсан. Үе үе л Р.Гаваа хурандаа хамгийн арын суудалд сууж харагддаг болов.

сэдсэн хэргээр ял зэм сонсох вий гэдгээ ч мэдэж л байсан. Гэхдээ л Ардын Армийн Улс төрийн газар өргөдлөө бариад орсон. Цэргийн газарт энгийнхэн ингэж холигдохгүй шүү гээд өнөөх өргөдлийг бараг өөдөөс шидсэн. Гэтэл өнөөдөр "Тэмүүжин-Өрлөг" гээд ЕБС-тай болчихсон байна шүү дээ. Хэн санаачилсан байх нь хамаагүй, боломжтой гэдгийг нь нотолсон нь л чухал. Ууртай даргын базсан өргөдлийг аваад гарахад арга мухардаж болохгүй гэдгээ л ойлгосон. Боломжийг холоос хайгаад хэргүүг юм билээ. Хажууханд ерөнхий боловсролын 44 дүгээр сургууль байсныг санаад тус сургуульд лицей анги нээнэ гэсэн хүсэлтээ захиралд нь танилцуулахад нааштайгаар хүлээж авсан. "Манай сургуульд цэргийн хүн больё" гэсэн хүсэл сонирхолтой сурагчид бий гээд уулзалтын өрөөнөөсөө л бараг ажлаа эхлүүлэв. Гэхдээ ганцхан удаа л тийм анги төгсгөсөн. Математик, физикийн хичээлийг манай сургуулиас сонгогдсон багш нар заадаг байлаа. Тэр ангийн

сурагчид төгсгөлтийн шалгалтад дүүргийн хэмжээнд өндөр үнэлгээ авч, эрэгтэй сурагчдыг бүгдийг нь ҮБХИС-д элсүүлэх зөвшөөрлийг сургалтын албаны дарга өгсөн байдаг. Тэгж элссэн сурагчдын нэг нь ЗХЖШ-ын орлогч даргаар ажиллаж байсан хошууч генерал Б.Баярмагнай шүү дээ. Эмэгтэй сурагчдыг тухайн үед ҮБХИС-д элсүүлдэггүй байсан ч тэдэнд зориулж анх удаагаа ар тал, эдийн засгийн ангийг нээсэн нь намайг бүр ч баярлуулсан шүү.

Хошууч генерал Р.Гаваа агсан таны хичээлд сонсогчидтой хамт суучихдаг байсан гэнэ лээ. Тэр үе рүү буцъя ...

-Тэр үед хошууч генерал Р.Гаваа хурандаа цолтой, сургуулийн захирал байсан. Нэг удаа энэ ер нь юу заадаг нөхөр вэ гэж сонирчихаад миний заадаг магадлалын онолын хичээлд суусан юм. Ангийн хамгийн арын суудлаас хичээлд оролцоно. Би ч биеэ барьж эвгүйрхэх зүйлгүйгээр тэр хүнийг байхгүй юм шиг л хичээлээ заана. Голдуу самбартайгаа, сурагчидтайгаа харьцаад босоогоороо л өнждөг байсан. Үе үе л Р.Гаваа хурандаа хамгийн арын суудалд сууж харагддаг болов. Миний заах арга барил их сонирхолтой санагдсан учраас тэгж хэвшсэн юм билээ. Бүр нэг улирал бүтэн суусан гээд бодохгүй юу. Харин хамгийн арын суудалд суудаг нь сонсогчдын өмнө эсвэл голд ороод санаа бодлыг нь сарниулахгүй гэсэндээ тэгсэн хэрэг. Шалгалттай өдөр ч ялгаагүй надад нэг "вариант" хуваарилаач гээд сууж байдаг сан. Одоо бодоход цайган, хүн хүнтэй нэг л зангаараа харьцдаг байж. Шалгалт дөхөхөөр над шиг тийм элдвийн юм сэдэж олдог хүн цөөн дөө.

Элдвийн юм гэхээр ...
-Хүний санаанд буухгүй тийм зүйл ч уг нь биш л дээ. Гэхдээ сонсогчдын үйлийг ёстой үздэг байсан байх гэж боддог. /Инээв/ Би 30 хүнд 30 өөр вариант өгчихдөг байж билээ. Хуулна гэдэг ойлголт ард хоцорсон шүү. Цаас л их үрсэн байх. Бас цаг хугацаа. Хүн нэг бүрт зориулан бодлого боловсруулаад засна гэдэг сүүлдээ өөрт ч төвөгтэй санагддаг болсон.

Та нас сүүдэр хэд хүрч байна вэ? Эргээд хичээл заагуулалтад бэлэн үү, авьяас тэтгэвэрт гардаггүй гэдэг үү бий ...

-Наян насны босгон дээр ирээд байна. Энэ жил 78 нас хүрсэн. Хичээл заана гэж ярих үе ч бас биш байх аа. Ер нь бусад өвгөчүүд насны бөгсөнд ач зээгээ хараад хамт тоглож суусаар хадан гэртээ очдог бол би тэгэхгүй гэж боддог. Хүүхдүүдээ ч түүнийгээ хэлчихсэн. Ээж бид хоёр чинь хүүхдүүдтэй зууралдаж сууж чадахгүй шүү, цэцэрлэг, ясли, сургууль гээд өөрсдөө болгоорой гэхихсэн. Угаасаа тэгж ядрахыг хүсэхгүй байна. Гэхдээ ач, зээдээ төрсөн хүүхдүүдээсээ ч илүү хайртай.

Танай хүн АШУДС-д суралцсан гэдгийг та дурдаад л өнгөрсөн. Анх танилцсан түүхээсээ хуваалцахгүй юу?

-Миний ханийг М.Оюунчимэг гэдэг, хүүхдийн эмч мэргэжилтэй. Шүдний эмч болно гэхэд нь би хүүхэд шиг гэнэн цагаахан юм хаана байна гээд хүссэн мэргэжлийг нь сонгуулаагүй юм. Хааяа уурлахаараа энэ түүхийг их сөхөж ярьдаг. Сангийн ач ахуйд техникумын оюутнуудыг аваад гарч байхад нь анх танилцсан. Дараа нь манай суманд ч сувилалч багшаар ажилласан.

Манай улсын боловсролын тогтолцоонд зургаан настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх нь хэр зохиомжтой вэ? Таны туршлагаар ...

-Цүнх хүндэддэг гэдгээс л эхэлнэ. Ийм насны хүүхдүүдийн тархи тийм их ачааллыг даахгүй юм шиг санагддаг. Энэ бол боловсролын тогтолцоонд өргөс байгаа л харуулж байна. Наад захын жишээ нь. Өөр олон өргөс бий. Насаараа боловсролын байгууллагад ажилласан "голыг тойрч биш гаталж гарсан хүн" учраас эмээглэдэг зүйлс бий.

Сонирхолтой яриа өрнүүлсэнд баярлалаа.



"ЦЭРГИЙН УЛС ТӨР, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН ЭВЛЭЛ" ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Эрхэм зорилго

Цэргийн доторх улс төр, соёл хүмүүжлийн ажлын өв уламжлал, шинэчлэлийг эрхэмлэн дээдэлж, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, үнэт зүйлсийг баталгаажуулах үйлсэд төр, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

"Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллага нь 2015 оны 6 дугаар сарын 6-ны

өдөр байгуулагдсан. Батлан хамгаалахын сайдын 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн тушаалын хавсралтад зааснаар жил

бүрийн 5 дугаар сарын 16-ны өдөр мэргэжлийн өдрөө тэмдэглэж байхаар тогтоосон. "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн

ажилтны Нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллагаас 2019 онд хэрэгжүүлсэн 10 онцлох ажлыг танилцуулж байна.

Бидний уриа

*Мэриэжил, боловсрол бидний нэрийн хуудас
Мэдлэг, туршлага бидний гавуу тал*

Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ЦАЛИНТНУУДЫГ АЛДАРШУУЛАВ



ЦЕДС, ЦНДС-ийн улс төрийн ангийг Д.Сүхбаатарын нэрэмжит цалинтай суралцаж төгссөн ахмад төгсөгчдийг алдаршуулах уулзалт-хүндэтгэлийн ажиллагааг УБХИС-д зохион байгуулж, сургуулийн музейд дурсгалын самбар байрлуулан үе үеийн онц төгсөгчдөд "Батламж" гардуулав.

ШИНЭ НОМЫН БАЯР



Цэргийн сэтгүүлч, бэлтгэл хурандаа Г.Нямдоржийн зохиож эмхэтгэсэн "Боевое братство" буюу "Халхын голын дайчин ахан дүүс" номын баярыг УБХИС-ийн "Тэмүүжин өрлөг" сургуулийн хурлын танхимд зохион байгуулав. Нээлтэд ОХУ болон Беларусь улсын Элчин сайдын яамны ажилтнууд, ЗХЖШ, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн ахмад, залуу багш нар, ахмад дайчдын төлөөлөл зэрэг 60 гаруй хүн оролцож, зочдод ном бүтээлээ бэлэглэв.

ОНОЛ ПРАКТИКИЙН ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд "Халхын голын дайнд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн улс төрийн байгууллага, ажилтнуудын гүйцэтгэсэн үүрэг" сэдвээр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, доктор, бэлтгэл хурандаа Б.Бадарч, доктор И.Чинбат, бэлтгэл хурандаа Г.Нямдорж нар илтгэл тавьсан бөгөөд ахмад улс төрийн ажилтнууд идэвхтэй оролцлоо. Уг арга хэмжээнд зориулан "Соёмбо" сонинд тусгай нүүр бэлтгэн гаргалаа.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛТНЫ ӨДӨР



Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн удирдлагын дэмжлэгтэйгээр тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу уг өдрийг зохион байгууллаа. Энэ үеэр БНМАУ-ын баатар Б.Цогийн хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлж, БНМАУ-ын баатар Л.Гэлэгбаатарын баатарлаг гавьяаг мөнхжүүлсэн танхимыг улс төрийн ахмад ажилтнууд үзэж сонирхсон. Мөн ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн бүрэн хэмжээний тоглолтыг ахмадууд, цэрэг дайчдад үзүүлэв. Энэхүү арга хэмжээнд цэргийн улс төрийн ахмад ажилтнаас бүрдсэн 120 гаруй хүн оролцсон.

ШИНЭ ДУУТАЙ БОЛОВ



БНМАУ-ын баатар Б.Цог, Л.Гэлэгбаатар нарын баатарлаг гавьяат үйлсийг мөнхжүүлэх зорилгоор яруу найрагч, бэлтгэл хурандаа Г.Ганбатын шүлэг, Ардын жүжигчин Ө.Баярмагнайгийн хөгжим "Баатар генерал Цог", ахмад О.Эрдэнэцогийн хөгжим "Хатан зориг Л.Гэлэгбаатар" зэрэг дууг ЦДБЭЧ-ын мэргэжлийн дуучид дуулж олны хүртээл болгосны зэрэгцээ дууны үг, ноотыг тусгайлан жаазалж ангид нь дурсгав.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ШАЛГАРАВ



Мэргэжлийн өдрийг тохиолдуулан ажил үйлсээрээ манлайлсан Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн соёл хүмүүжлийн дарга, ахмад Ө.Нарантуяа Нэгдсэн эвлэлийн хүндэт өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдав.

ШИНЭ НОМ ХЭВЛЭГДЛЭЭ



"Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллагаас анхлан санаачилсан БНМАУ-ын баатар цол хүртсэн 46 хүнд зориулсан шүлэг, яруу найргийн "Дуунд мөнхөрсөн баатрууд" номыг хэвлүүллээ. Уг бүтээлд дайнд оролцсон анги, салбарууд, баатруудын гавьяат үйлсийг багтаасан ба Улсын үндэсний номын сан, МУИС, ШУТИС, СУИС болон 21 аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабуудад хүргүүлсэн. Номын нээлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Офицеруудын ордонд зохион байгуулсан бөгөөд хүндэт зочид, баатруудын ар гэр, төрөл төрөгсөд, үр хүүхдүүд оролцлоо.

ЦЕДС-ИЙН ТӨГСӨЛТИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭВ



ЦЕДС-ийн 49 дэх удаагийн төгсөлтийн 40 жилийн ойд зориулж "Соёмбо" сонинд тусгай нүүр бэлтгэн, "Нэг оныхон, нэг ротынхноо дурсахуй" нийтлэлийг "Соёмбо" сонинд хэвлүүллээ. Энэ үеэр 10 гаруй ахмад дайчинд БХЯ-ны шагнал хүртээсэн юм.

НОМЫН БАЯР-ДУРСАМЖ УУЛЗАЛТ



"Номын баяр-Дурсамж уулзалт-2019" өдөрлөгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Офицеруудын ордонд ЗХЖШ-ын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс, "Соёмбо" сонины редакт, ЦДБЭЧ-тай хамтран зохион байгууллаа. Энэ үеэр УБХИС, ШУТИС-ийн номын сан, ахмад ажилтнуудын ном бүтээлээр үзэсгэлэн гаргаж, ном танилцуулах, солилцох, бэлэглэх, хандивлах арга хэмжээг явуулсан ба "Монгол цэргийн нэгдсэн холбоо"-нд 100-аад номыг бэлэглэв.

БАГШИЙН АЛДРЫГ ТЭМДЭГЛЭВ



УБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимтэй хамтран "Багшийн алдар" уулзалт өдөрлөгийг зохион байгуулж, ахмад багш Б.Дуламсүрэнг алдаршуулан хүндэтгэл үзүүлэв. Арга хэмжээнд Монгол Улсын гавьяат багш Г.Мягмаржав, А.Гэлэгжамц, ахмад багш, доктор, профессор С.Баатар, Н.Ядмаа болон үе үеийн төгсөгчдийн төлөөлөл, оюутан залуус зэрэг 70 гаруй хүн оролцлоо.

БАЙГУУЛЛАГААС ЖИЛ БҮР ЗОХИОН БАЙГУУЛДАГ УЛАМЖЛАЛТ АЖЛУУД

Төгсөгчдийн нэрэмжит биеийн тамир, спортын уралдаан тэмцээн:

- Гар бөмбөг /1992 оны төгсөгчид/
- Сагсан бөмбөг /1990 оны төгсөгчид/
- Ширээний теннис /1977 оны төгсөгчид/
- Дартс шидэлт /1981 оны төгсөгчид/
- Шатар /1983 оны төгсөгчид/
- Снукер билиард /Гадаадын сургууль төгсөгчид (Минск, Львов)/

Мэргэжлийн өдөр (Жил бүрийн 5 дугаар сарын 16)

2016 оноос эхлэн дөрвөн удаа тэмдэглэсэн.

Хүндэт дэвтэр

2018 оноос эхлэн өнөөдрийг хүртэл 10 гаруй хүнийг алдаршуулан гэрчилгээ олгосон.

Төрөлх сургууль, тэнхимийн хамтын ажиллагаа

Жил бүрийн 1-12 дугаар сард сургууль, тэнхимдээ тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлдэг.

Ахмад ажилтнуудын нэгдсэн золголт

Жил бүрийн сар шинийн 15-ны дотор зохион байгуулдаг.

Санаачлан хэвлүүлсэн шинэ номууд

1. Доктор Лха.Баяр "Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Цэрэг, ардыг сурган боловсруулах газрын түүхэн товчоон" 2018 он,
2. Г.Ганбат, Б.Отгонбаяр "Дуунд мөнхөрсөн баатрууд" 2019 он.

Цэргийн улс төрийн ажилтнуудад зориулсан дуу, яруу найраг

1. МУСТА, яруу найрагч, бэлтгэл хурандаа Г.Ганбатын шүлэг, хөгжмийн зохиолч Ж.Даваагийн аялгуу "Хөх Монголын хатан зоригтнууд",

2. Монголын Зохиолчдын Эвлэлийн "Утга зохиолын төлөө" шагналт зохиолч, яруу найрагч, МУСТА, ахмад улс төрийн ажилтан, доктор, профессор, чөлөөнд байгаа дэд хурандаа Н.Ядмаагийн үг, ая "Комиссарууд"

2020 онд хэрэгжүүлэх үндсэн ажлууд:

> "Төрийн бус байгууллагын нэг өдөр" арга хэмжээг Зэвсэгт хүчний ангиудад тусгай хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохион байгуулах

/1, 2 дугаар сард/

> Хил хамгаалах Ерөнхий газрын удирдлага, ХЦДБЧ-тай хамтран "Дуунд мөнхөрсөн баатрууд" номыг танилцуулах уулзалт өдөрлөг

/1 дүгээр сард/

> Хоёр дайнд оролцсон, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хошууч генерал Ч.Данзангийн гавьяат үйлсийг мөнхжүүлэх ажлыг зохион байгуулах

/1, 2 дугаар улиралд/

> МАА-ийн Улс төрийн газрын дарга агсан, Чөлөөлөх дайнд оролцсон, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн мэндэлсний 100 жилийн ойг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлэх

Монгол цэргийн музей, Нэгдсэн эвлэл ТББ /4 дүгээр сард/

> Чөлөөлөх дайнд Ардын цэргийн улс төрийн байгууллага, ажилтнуудын гүйцэтгэсэн үүрэг" сэдвээр хэлэлцүүлэг зохиох, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах, ном бүтээл гаргах.

"Соёмбо" сонин, ТББ /1-9 дүгээр сард/

> Зэвсэгт хүчний 016 дугаар бригад "Дуунд мөнхөрсөн баатрууд" номын нээлт, урлаг, соёлын арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.

ТББ, ЦДБЭЧ /5 дугаар сард/

> Төгсөгчдийн нэрэмжит биеийн тамир, спортын уралдаан тэмцээн. ТББ, хариуцсан төгсөгчдийн төлөөлөл /4 дүгээр сараас/

> "Номын баяр-Дурсамж уулзалт 2020" өдөрлөгийг Офицеруудын ордонд зохион байгуулах /11 дүгээр сард/

> УБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимтэй хамтран ажиллах, уулзалт өдөрлөг, номын нээлт /12 дугаар сард/

> Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Цэргийн улс төрийн ажилтан" төгөлийг шинээр байгуулах.

ТББ, гишүүд дэмжигчид /5 дугаар сард/

ХОЙМОРЬ



“Аяллын цаг” нэвтрүүлгийн эзэн, сэтгүүлч, судлаач Г.БАДАМСАМБУУГ “Хойморь” булангийнхаа анхны зочноор урилаа.

Цэнхэр дэлгэцээр таны намуухан зөөлөн хоолой, урсгал гол шиг хүүрнэн өгүүлсэн тогтуун яриаг сонсож өссөн. Харин өнөөдөр нэвтрүүлгийн тань тухай яриа дэлгэж суугаадаа баяртай байна ...

-Баярлалаа. Надтай уулзсан хүн бүр нэвтрүүлэгтэй минь холбоотой урмын үгийг харамгүй хайрладаг юм. “Аяллын цаг” минь намайг сэтгүүл зүйд тодоос тод тамгалсан нь амьдралын маань аз жаргалтай дурсамжийн нэг болон үлдэж дээ.

Нэвтрүүлгээ бүр мөсөн зогсоосон юм уу?

-Сүүлийн таван жил нэвтрүүлгээ хийсэнгүй. Нэгд, улс төрийн намын шахалт, хоёрд, судалгаа, тэр дундаа түүх судлалд илүү их цаг зарцуулах болсон зэргээс улбаатай. Хэрхэхийг цаг хугацаа

болгосон зүйл. Миний бодлоор цагаа олоогүй ямар ч агуу зүйл амжилт олдоггүй. Туршлагаас харахад ч тийм юм. Харин цагаа олсон өчүүхэн зүйл ч амжилт олдог гэдэг шиг би цагаа олсон азтай хүн. Монголчууд удаан хугацаанд буюу Манжийн дарлалын 200 жилээс эхлээд Зөвлөлтийн нөлөөллийн үе хүртэл хүн төрөлхтнөөс нуугдмал, бөглүү, таних мэдэх хэрэгцээгээ хязгаарлуулсан байсан нь энэ нэвтрүүлэг амжилтад хүрэх үндэс байжээ гэж боддог юм. Тэгэхээр та нэг зүйлийг ойлгож уу?

Мэдэх хэрэгцээ их байсан нь нөлөөлж гэж ойлголоо ...

-Миний чадалтайд биш, ийм хэрэгцээ байсанд гол утга оршиж байгаа юм. Эхлээд нэвтрүүлгээ хийх гэж ёстой нэг балладаг байлаа. Залуу насныхаа ааг омгоор л явдаг байж дээ. Камераа тэврээд, замын машинд суугаад уул хадаар хэдэн

Г.Бадамсамбуу: АМЬДРАХ ЧАДВАРААС ЗАЙЛСХИЙСЭН ИРГЭНШЛИЙН ҮЕ ИРЖ БАЙНА

харуулах биз.

“Аяллын цаг”-ийг хэзээнээс хэрхэн эхлүүлж байсан талаараа ярихгүй юу?

-1990-ээд он хүртэл монголчууд эх орондоо итгэх итгэл тун багатай байлаа. Шалтгаан нь хөгжил, цэцэглэлтэй холбоотой. Хоёрдугаарт, гадаадын орныг тахин шүтэх сэтгэлгээ давамгайлж байсан нь нөлөөлсөн байж таарна. Тэгээд би гэдэг нөхөр 1997 оны намар Их Британид очиж хагас жил амьдраад ирэхдээ “Дэлхийн орнуудын хөгжил, түүх, соёл уламжлал, угсаатан зүй, амьдрах ёс зэргийг нь харуулсан нэвтрүүлэг хийе” гэдэг шинэ санаа, хүсэл мөрөөдөлтэй ирсэн. Ирэхдээ боломжийн “хөөрхөн” тоног төхөөрөмж авчирсан юм даг. Нийгэм, цаг үе хүнд, иргэдийн аж амьдрал амаргүй байхад шүү дээ. Тэгээд анхны бүтээлээ 1998 онд “Бурхан халдун”-ы тухай баримтат нэвтрүүлгээр эхлүүлэн 1999 оноос үндсэндээ тогтворжуулж, “Гараг” продакшныг байгуулсан. Ингээд анхны нэвтрүүлгээс хойших 20 орчим нь дан гадаад, тэр дундаа Европын орнуудын тухай бэлтгэсэн. Тэгэхэд тухайн орнуудын иргэд их гайхаж байсан. “Монгол хүн, монгол сэтгүүлч аялж байгаа гэж үү? Зөвхөн орос, америк сэтгүүлч нар л аялдаг биз дээ” гээд л. Их сонин хүлээж авч байсан шүү.

Та бас эх орныхоо өнцөг булан бүрийг нэвтрүүлгээрээ тольдон харуулсан ...

-Тэр мэдээж. Хорь гаруй жилийн хугацаанд дэлхийн 60 гаруй орноор аялсан ба эх орноо бүтэн тойрсон байна. Долоо хоног тутмын нэвтрүүлэг гэхээр жилд дунджаар 40 орчим, 20 гаруй жилийн хугацаанд 700 гаруй нэвтрүүлгийг олны хүртээл болгожээ. “Аяллын цаг” нь үзэгч олондоо өөрийн өнгө төрхөө дархлан үлдээснээс гадна аяллын сэтгүүл зүйг хөгжүүлэн иргэдэд эх орноороо бахархах үзэл, хүмүүжлийг олгосон баявчтай нэвтрүүлэг гэж би боддог. Яагаад гэж та асуух байх. Энэ нэвтрүүлгийг бэлтгэн гаргахаас өмнө аяллын нэвтрүүлэг гэж бараг байгаагүй. Цөөн тоотой байсныг үгүйсгэхгүй. Гэхдээ тэр нь тогтвортой бус, жилдээ ганц, хоёр л удаа гаднын орны тухай аян замын тэмдэглэл байдлаар гарч байж. Харин “Аяллын цаг” нэвтрүүлэг гарснаар дэлхийн орнуудын түүх, соёл, уламжлал, аж төрөх ёс, зан заншил гээд олон зүйлийг нь нийтэд гаргаж эхэлснээрээ иргэдийн мэдэх эрхийг хангаад зогсохгүй аяллын сэтгэл зүйн суурь баазыг бэхжүүлж, хөгжүүлсэн. Та бод л доо. Өнөөдөр телевиз бүр аяллын нэвтрүүлгийн хүний нөөцтэй, өөрийн гэсэн хөтөлбөртэй болсон байна шүү дээ. Нөгөө нэг сайн үр дагавар нь гаднын орныг тахин шүтэхээс илүү эх орныхоо үзэгчлэлтэй байгалиар бахархах, гэр бүл, найз нөхдөрөө зугаалж, аялдаг болсонд гол учир нь оршиж байна. Энэ бол миний туйлын хүсэл мөрөөдөл байсан. Мэдээж үүнийг ганцхан нэвтрүүлгээрээ бий болгосон гэж хэлэхгүй. Хүний мэдэх, сонжих, сонирхох эрх дээр нь тулгуурлан өөрийн хувь нэмрээ оруулсан гэдэг л хамгийн чухал. Бас нэг дурдах ёстой зүйл бол монгол сэтгүүлч анх удаа цүнх үүрээд, камер бариад дэлхийг тойрж, эх орноо бүтэн эргэсэн. Энгийн хүүрнэл яриагаар ярих хэв маягийг гаргаж ирсэн зэрэг нь энэ нэвтрүүлэг буюу миний бий

Өнөөдөр нийгэмд компьютер, гар утаснаас эхлээд бүгд техникжсэн, тийм нэг сул дорой, хэт их нялхамсуу, хэт их соёлжуу иргэн болон төлөвшиж байна. Хэт их соёлжуу, нялхамсуу, технологжсон байх нь бүтээлч чадварыг сулруулдаг талтай. Энэ утгаар нь 18 нас хүрсэн эрэгтэй хүн бүрийг заавал цэргийн албаар дамжуулан жинхэнэ эр хүн, жинхэнэ иргэн болгоход Зэвсэгт хүчин онцгойлон ажиллах ёстой.

хоног, сараар явчихна. Зэрлэг ан амьтнаас айж сүйд болсон ч юм байхгүй. Гэр бүл, найз нөхөд маань “Чи их тэнэг хүн юм. Хамгийн их зардалтай, бартаа ихтэй сэтгүүл зүйг сонголоо” гэж загнаад л. Эхний дөрвөн жилд ганцаараа энэ жимээр л явсан. Нэвтрүүлэг жаахан олны танил болоод ирэхэд олон улсын байгууллага, гадаадын орнуудын Элчин сайдын яамдын урилгаар дэлхийн орнууд руу уригдаж, орон нутгийн удирдлагуудын хүсэлтээр нь эх орныхоо хүссэн газар очиж нэвтрүүлгээ бэлтгэсэн байна. Одоо бодоход аяллын сэтгүүл зүй их хүнд ажил байж дээ. Тэр үедээ сайхан байна, болж байна гэж л боддог байв. МҮОНРТ-ийн “Цагийн хүрд”, “Аяллын цаг” хоёр хэдэн жилдээ үзэгчдийнхээ тоогоор хамгийн оргил нь болж, түүнд нь ихэд урамшин “давхисан” байна. Нээрээ үзэгчид их сонирхохын хэрээр миний өмссөн хувцас хүртэл “мода” болсон шүү.

Тийм гэж үү?

-Тэр үед хөдөө явдаг хүмүүс бүрх малгай, олон халаастай майк өмсдөг болж эхэлснийг одоо ч тод санаж байна. Надтай хамтран ажиллаж байсан аяллын барааны “Аянч” дэлгүүрийн орлого хүртэл сууга нэмэгдэж байлаа шүү дээ. Одоо хааяа нэг оюутан залуучуудтай уулзахаар “Тань шиг аялагч, сэтгүүлч болмоор байна” гэдэг юм. Тэгэхэд нь “Би цаг нөхцөөх гэж нэвтрүүлгээ хийгээгүй. Энэ миний бага насны мөрөөдөл. Миний аав үлгэрч хүн байсан. Үлгэр гэдэг хамгийн их адал явдал, мөрөөдлийг бий болгодог зүйл. Уншиж сурснаасаа хойш адал явдалтай номноос бас салаагүй. Зохиолд гарч байгаа оронд очиж үзэх сэн, түүх, соёл, уламжлал нь их өвөрмөц юм, бодитоор харах сан гэсэн туйлын хүсэл намайг аялагч, сэтгүүлч болгосон. Та нар мөрөөд, хүс, хичээ” гэж хэлдэг юм. Үнэхээр л би зохиолд гарсан орнууддаа очиж үзсэн. Сонирхлоо мэргэжил болгоод түүгээрээ амжилт олно гэдэг

их азтай явдал. Магадгүй Монголд надаас илүү аялсан, нэвтрүүлэг бэлтгэсэн хүн байгаа байх. Голдуу дипломат шугамаар. Харин миний хувьд мөрөөдлөө таашаал, мэргэжил болгож явсан учраас амжилтад хүрсэн.

Санаанаас гардаггүй ямар аялал байдаг вэ. Улс болгоны аж төрөх ёс, угсаатан зүй бүр харилцан адилгүй биз ...

-Яривал хэдэн өдрийн ажил болно. Маш олон адал явдал, дурсамж байна. Хамгийн тод санагдаж байгаа нь Шотланд, Израиль хоёр. Израиль яагаад сонин гэвэл цөлд хэзээ ч бүтэшгүйг байгуулсан орон. Тэрхүү газар нутгаа 2000 жил орхиж явчихаад 1948 онд буцаж ирээд тийм зүйл байгуулсан гэдэг гайхалтай. Үнэхээр гайхамшигтай. Дэлхийд том биш гэхдээ супер орон. Цөлийг яаж усжуулж, соёлжуулж болдгийг, саяхан нэгдсэн хүмүүс хэзээнэй л юм шиг оршиж, тэгээд бас хүчтэй байж болдгийг тэндээс л олж харсан. Хүчирхэг байдал болон хөгжил цэцэглэлтэд нь угсаатны үнэт зүйл, сүсэг бишрэл нөлөөлсөн байх. Яг үүн дээр жишээ авч хэлэхэд өнөөдөр манай залуус “Шинжлэх ухаан байвал болчихно. Бодит зүйл хамгийн чухал” гэдэг инээдтэй зүйл их ярьж байна. Нөхцөл байдал ердөө тийм биш. Шашин, шинжлэх ухаан хоёр хамтдаа оршин байж хүчирхэг болдог юм. Шашин бурхны номлол нь үнэн биш боловч хүмүүст биет бус хүчтэй сэдэл төрүүлдэг. Оюун санаагаараа олж болох чухал биет бус зүйл гэсэн үг. Тэгэхээр ухаантай орчин үеийн хүн гэдэг нь шашны талаар ч тэр, уламжлалын талаар ч тэр сайн мэдлэгтэй, тэнцвэрт байдлыг хадгалдаг хүнийг хэлнэ. Зөвхөн шинжлэх ухаанч байх эсвэл зөвхөн шашинлаг байх нь мунхрал. Шинжлэх ухаанч, бодит байдлыг эрхэмлэх нь чухал, гэхдээ ингэж туйлшруулах нь оюун санааны хүчийг сулруулдаг. Шинжлэх ухаанч хүн хэзээ ч театр руу очиж, уран зохиолын ном унших шаардлагагүй болдог байхгүй юу. Мөрөөдөл бол шинжлэх ухаан биш. Хүсэл тэмүүлэлтэй хүн амжилтад хүрнэ. Мөрөөдөгч, сониуч байх нь амжилтад хүрдэг хүмүүсийн хамгийн гол үндэс нь. Амьдрал дээр ч ийм л байдаг.

Та дэлхийд тархан суурьшсан монголчуудын тухай нэлээд нэвтрүүлгийг бэлтгэн гаргасан. Тэдний туйлын хүсэл нь юу байна вэ?

-Дэлхийн монголчуудын олонхтой нь очиж уулзсан. Тэдэнд ирээдүйд одоо байгаа нөхцөлөө хэрхэн дээшлүүлэх вэ гэдэг ганцхан хүсэлт, зорилго байгаа. Оюун санааны болоод угсаатны хувьд урам дэм авах гол найдлага нь мэдээж Монгол Улс. Тэр байгаа газар орондоо ямар байхаас үл хамааран уугуул Монгол орон тэдний бахархал болж байвал тэд сэтгэл нь ханаж байдаг улс. Өөрөөр хэлбэл, Монгол Улс хөгжил өндөртэй, хүчтэй байвал тэд “Бид Монголын ахан дүүс” гэж цээж дүүрэн бахархаж чадна. Тэр хэрээрээ “Бид Монгол угсаатай” гэдгээ санаа зоволгүйгээр ам бардам хэлдэг болно. Надтай уулзсан монгол үндэстнүүдийн маань хэлдэг нэг л үг байдаг. “Монгол хөгжөөсэй” гэж. Энэ бол ирэх гэсэндээ огт биш. “Монгол руу нэгдэх гэсэн далд санаатай” гэж зарим хүн ярьдаг л юм. Одоо нэгдэнэ гэж юу байх вэ дээ. Нөгөө талаас

дэлхийн монголчууд хоорондоо геополитикийн бодлого явуулж чадахгүй ч өөрсдийн гэсэн соёлын геополитикийн орон зайтай. Үүгээр нь дамжуулан хамтарсан соёлын арга хэмжээг зохион байгуулахаас эхлээд олон талаар “Монгол” гэдэг бахархлыг нь улам лавшруулах боломжтой гэж харж байна.

Та залуучуудтай хийсэн нэг уулзалтын үеэрээ аливаа зүйл хөгжлийнхөө эхлэлд эргэж очдог тухай ярьсан. Энэ тухай тайлбарлахгүй юу?

-Аливаа зүйл ромбо маягаар хөгждөг. Өнөөдөр зарим зүйл цоо шинэ юм шиг санагддаг атлаа тэр нь ямар нэгэн юмны хуучин холбоо байдаг. Юу ч уламжлалаас тасардаггүй. Уламжлал, шинэчлэл хоёр хэлхээ холбоотой. Уламжлалт амьдрах ухаан, уламжлалт технологи, байгалийн хуулиуд эргээд заавал хэрэгжиж байдаг дүрэмтэй. Зарим нь бүр уламжлалаараа дархлагдсан хэрэглээний хэв маяг болчихдог. Үүний жишээ нь нүүдэлчид. Нүүдэлчдийн амьдрал нь зөвхөн гэр бүлдээ зориулсан хэрэглээний үйлдвэрлэл явуулдаг. Малаа өсгөх нь ч тэр. Цагаан идээгээ боловсруулах нь ч тэр, малаа нядлах нь ч тэр. Сур, ган үйлдвэрлэл ялгаагүй өрхийн хэрэгцээнд зориулагддаг.

Та одоо юу хийж байгаа вэ?

-Судалгаа хийж, хэд хэдэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байна. Удахгүй баримтат бүтээлийн цуврал төсөл эхлүүлнэ. Мөн хүүхдийн болон монголчуудын түүхэн газрын тухай төсөл ч бас байна. Хийх ажил тун ихтэй явна. Судалгааны бүтээл хийх нь хөгжмийн зохиол, яруу найраг бичихтэй адил тийм гоё гэж бодож байгаагүй. Одоо бол тийнхүү бодох болсон. Яагаад гэвэл судалгааны үр дүнгээр тайлсан шинэ нууцууд, эздэрээ, учир жанцанг нь олсон зүйлс дараа нь нийгэмд тодорхой хэмжээнд мэдлэг үйлдвэрлэх нь чухал юм байна гэж ойлгосон. Ер нь цаашдаа яах вэ, хойч үедээ зориулж үлдээчихсэн байх хэрэгтэй. Хувь хүний зүгээс энэ бол нэр алдрын төлөө биш юм. Би чинь нэг талаар их сонин хүн. Бусдын хийгээгүй юмыг хийе л гэж боддог, багаасаа л тийм хачин мөрөөдөлтэй байж. Сайн баримтат бүтээл, сайн гэрэл зураг, сэтгүүл зүйн сайн төрөл, зүйлүүдийг бусдаас илүү хийж байж, түүнээсээ таашаал авах аминчхан гэмээр юм уу, хувийн бодолтой хүн. Бас миний хэв маяг цаг, нар, элдэв зүйлд захирагдаж үзээгүй. Өөрийнхөө дурдаар л ажилладаг. Ямар ч амралтгүй ажиллаж чадна, эсвэл хэдэн өдрөөр ч амарч бас чадна.

Бидний асуух дуртай асуулт бол салбарынхаа тухай. Та Зэвсэгт хүчнийхээ өнөөгийн хөгжил дэвшлийг хэрхэн үнэлж байна вэ? Тантай ойр салбар мөн үү?

-Яг одоо миний хувьд Д.Сүхбаатар жанжны тухай бүтээл хийж байгаа. Энэхүү судалгааг хийж байхад надад их сонин зүйл ажиглагдлаа. Юу гэхээр цэргийн эзэнт гүрэн мөхөж сэргэхээрээ ямар байх бол гэдэг нь хамгийн сонин. Үнэхээр сонин. 1911 оны Богд хаант Монгол Улсын цэрэг, 1921 оны Хувьсгалын цэрэг бол дэлхийн талыг эзэлж байсан их гүрний мөхөөд гарч ирж байгаагийн хэлбэр нь тэр. Тэгвэл энэхүү хоёр хувьсгалыг төлөөлүүлээд гаргах цэрэг хэн байх вэ гэхээр Д.Сүхбаатар жанжин юм билээ. Д.Сүхбаатар жанжин 1911

оны Богд хаант Монгол Улсын үед бэлтгэгдсэн орчин үеийн анхны цэрэг. Бэлтгэгдэж явсаар 1921 оны хувьсгалын гол жанжин болсон энэ хүнээр л Чингис хааны үеийн цэрэг яаж сэргээхийг төлөөлүүлж үзэх юм байна гэж бодогдож байна.

Үнэхээр сонирхолтой санагдаж байна. Хэзээ олны хүртээл болох вэ?

-Энэ тухай ярих хараахан болоогүй. Надад нэг л зүйл тодорхой харагдаж байна. Надад гэлтгүй түүхчид ч хэлдэг шүү дээ. Монгол Улсын түүх тэр чигтээ цэргийн түүх гэж. Монгол Улс их гүрэн байсны хувьд цэргийн түүхээр угсаатны түүх бичигдсэн юм бол бид хүчтэй армитай байж, өндөр хөгжилтэй улс магадгүй аль хэдийн болох байж. Жишээлбэл, Израиль хэзээ ч хүчтэй армитай улс байгаагүй. Вашинглаг улс байснаа өдгөө цэргийн тулгуурт орон болсон байна. Харин Монгол Улс цэргийнх байснаа иргэний шинжтэй улс болчихоод байна. Хэдийгээр бид цөөхүүлээ ч гэсэн орчин үеийн зэвсэг, техникээр зэвсэглэгдсэн хүчирхэг армитай болох ёстой. Өнгөрсөн онд Чойбалсан хотод болсон Монгол, Оросын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ” сургуулийн хаалтын ёслолыг үзэх завшаан тохиосон юм. Оросуудын танк, байлдааны онгоц, хуягт техникүүд нь ямар агуу юм гэв. Хэдийгээр бидэнд дайны аюул, газар нутгийн зөрчил байхгүй тайван улс ч гэсэн Зэвсэгт хүчнээ зэвсэглэл, техникээр нь бүрэн хангах ёстой. Бэлтгэл гэдэг нь зөвхөн хүн нэг бүрийн бие бялдрын бэлтгэлээр хэмжигддэггүй. Нөгөөтэйгүүр манай Зэвсэгт хүчний бодлого бидний үр хүүхдүүдийг эх оронд үзлээр хүмүүжүүлж, сургаж бэлтгэхээр хязгаарлагдахгүйгээр энхийг сахиулах үйлс буюу дэлхийн бодлогод оролцох болсон нь маш зөв алхам. Цаашид энэ чиглэлд илүү бэхжих хэрэгтэй. Өнөөдөр Монголын хамгийн эвгүй үе ирж байна шүү.

Ямар үе ...

-Амьдрах чадвараас зайлсхийсэн иргэншлийн үе. Өнөөдөр нийгэмд компьютер, гар утаснаас эхлээд бүгд техникжсэн, тийм нэг сул дорой, хэт их нялхамсуу, хэт их соёлжуу иргэн болон төлөвшиж байна. Хэт их соёлжуу, нялхамсуу, технологжсон байх нь бүтээлч чадварыг сулруулдаг талтай. Энэ утгаар нь 18 нас хүрсэн эрэгтэй хүн бүрийг заавал цэргийн албаар дамжуулан жинхэнэ эр хүн, жинхэнэ иргэн болгоход Зэвсэгт хүчин онцгойлон ажиллах ёстой. Одоо ч ажиллаж байгаа л даа. Гэхдээ миний гол санаа бол цэргийн албыг биеэр хаахаас өөр хэлбэрүүд байх шаардлагагүй юм шиг санагддаг. Өвчний учир мэдээж байх ёстой. Яг үндэндээ миний дээд үе буу бариад гарахад л бэлэн хүмүүс байсан. Миний үеэс эхлээд аажим аажмаар буурч, өнөөдрийн нийгэмд бүр эмэгтэйлэг эрчүүд гарч ирж байх жишээтэй. Энэ байдал удаан үргэлжилвэл магадгүй ижил хүйстэн ч олшрохыг үгүйсгэхгүй. Хоёрдугаарт, өнөөдөр Зэвсэгт хүчин улс орныхоо бүтээн байгуулалтад оролцож, нийгэмдээ зам, барилгын инженерүүд буюу бүтээгчдийг дэмжих байгаа нь үр дүнтэй арга. Энэ их сайн арга. Төрд ийм механизм хэрэгтэй.

Ер нь судалгааны явцад анзаарагдсан зүйл нь Монгол Улс олон мянган жилийн түүхэнд энэ их олон гүрэн, улс оронд дагаар оролгүй оршин байгаагийн шалтгаан нь цэргийн зохион байгуулалт бүхий орон байсантай холбоотой юм байна. Хэрэв бид цэргийн бүтэцгүй байсан бол Монгол гэж байхгүй, энэ том иргэншлүүдэд аль хэдийн ууссан байх байсан. Энэ үнэн шүү.

Сонирхолтой яриа дэлгэсэнд тань байрлалаа. Дэслэгч Д.БОЛОРМАА

Байлдагчийн дэлгэц



ЭХ ОРНЫ ИХЭР ХӨВГҮҮД

Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн дэд түрүүч Э.Дээдлэхзаяа, байлдагч Э.Дэлгэрэхзаяа хэмээх ихэр хөвгүүдийг энэ удаагийн дугаартаа онцолж байна. Ихэр хөвгүүд нуруу, царай, нүүрний баясгалантай байдлаараа тун төстэй бөгөөд тэдний гол ялгаа нь дэд түрүүчийн уруул дээрх мэнгэ. Тэд 2019 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд Нийслэлийн Хан-Уул дүүргээс татагдаж ирсэн залуус. Ихрүүд анх их, дээд сургуулиа төгсчихөөд цэргийн алба хаана гэж төлөвлөж байсан ч энэ бодол нь цэрэг татлагын үеэр өөрчлөгдсөн гэнэ. Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас хоёр ихрийг тэнцлээ гэхэд нь "Уул нь сургуулиа төгсчихсэн бол" гэсэн бага зэргийн эргэлзээтэй ирсэн ч өнөөдөр энэ нь 100 хувь өөрчлөгдөж, бүр эзэмшиж буй мэргэжлээрээ цэргийн салбарт үргэлжлүүлэн ажиллах хүсэл, мөрөөдөлтэй болжээ. Дэд түрүүч Э.Дээдлэхзаяа ЭМШУИС-д уламжлалын их эмч мэргэжлээр, байлдагч Э.Дэлгэрэхзаяа "Этүгэн" дээд сургуульд эмнэлгийн тоног төхөөрөмж, ашиглалтын инженер мэргэжлээр суралцаж аж. Хоёул гуравдугаар дамжааны оюутан бөгөөд цэргийн алба нэр төртэй хаачихаад Цэргийн төв эмнэлэг болон инженерийн цэргийн ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах мөрөөдөлтэй болжээ. Ихрүүд айлын том нь гэнэ. Э.Эрдэнэбаясгалан,

Э.Эрдэнэбаяа гэдэг дүү нартай. Цэрэгт ирснээсээ хойш дүү нараа бас өвөөгөө бага зэрэг санаж байгаагаа хуучлав. Тэд өвөө Н.Гомбодоржийгоо нийслэлийн Налайх дүүрэг дэх Зэвсэгт хүчний ангид захирагчаар ажиллаж байсан, хурандаа цолтой, насаараа тэнгэрээр ниссэн нисгэгч гэж тодотгов. Өвөө нь өдгөө 70 гарч яваа буурал байдаг бөгөөд ихэр ач нарынхаа Цэргийн тангараг өргөх ёслолын үеэр "Овоо доо, миний хүүхдүүд. Та хоёроос одоо эх орон үнэртэж байна. Эх орноо гэсэн үзэл, хүмүүжил харц, үйл хөдлөл, сэтгэлээс чинь мэдрэгдэж байна" гээд хацар дээр нь үнссэн гэнэ. Өвөөгийнхөө итгэл найдварыг алдалгүй, цэргийн албаа үлгэр жишээ хаах нь тэдний ойрын зорилго аж. Хөвгүүдийн аав Ц.Энхболд Иргэний нисэхийн Ерөнхий газар, ээж Г.Хашцэцэг "Чингис хаан" олон улсын нисэх буудалд ажилладаг, мөн л Цэргийн тангараг өргөх ёслолын үеэр ихрүүдээ бахдан биширсэн нь эрч хүч, урам зориг нэмжээ. "Та хоёрыг ялгахад амаргүй юм. Багад нь ангийнхан нь ялгадаг байв уу" гэхэд дэд түрүүч Э.Дээдлэхзаяа "Яг найзлаад ирэхээр ялгана. Тэгээд ч гол ялгаа нь миний мэнгэ болдог. Бид хоёр багадаа өөр, өөр авиа гаргаж үйлдэж байсан гэсэн. Гэрийнхэн гаргаж буй авиагаар нь "Инга, Инна" гэж дууддаг, найз нар ч ялгаагүй. Харин оюутан ангийнхан "Солонгос киноны нэр шиг" гээд шоолоод л байгаа. Гэхдээ бид энэ нэрэндээ хайртай" гэлээ. Тэрээр цааш нь "Цэргийн албанд ирснээсээ хойш миний хацар жаахан таргалаад байгаа. Ангийн захирагч намайг "Нөхөр

минь, ихрийнхээ хоолыг булааж идээд байгаа юм биш биз" гэж шоолсон шүү" гээд баахан инээв. Дэд түрүүч Э.Дээдлэхзаяагийн хувьд өнгөрсөн оны 10 дугаар сараас 11 дүгээр сарын дунд үе хүртэл ангийнхантайгаа хамт улс орны бүтээн байгуулалтад оролцсон байна. "Бүтээн байгуулалтад оролцсон маань миний бахархал байх болно. Манай ангийнхан улс орны бүтээн байгуулалтад манлайлан оролцдог ороо алдартай. 2019 он гэхэд Дорнод аймгийн Халх гол сумын "Шинэ сум" төсөл болон Дорноговь аймаг дахь төмөр замын бүтээн байгуулалтад оролцсон, үргэлж завгүй байдаг бүтээгч анги" гэж онцолсон юм. Ихрүүд чөлөөт цагаараа спортоор хичээллэдэг гэнэ. Дэд түрүүч Э.Дээдлэхзаяа гар бөмбөгийн спортын нэгдүгээр зэрэгтэй бөгөөд ЭМШУИС-ийн салбар сургуулийнхаа шигшээ багт, байлдагч Э.Дэлгэрэхзаяа нь хоёрдугаар зэрэгтэй, "Этүгэн" дээд сургуулийн шигшээ багт хамаардаг байна. Ихрүүдийн авьяас чадвар үүгээр зогсохгүй, Э.Дэлгэрэхзаяа цэнгээнт бүжгээр хичээллэдэг, сургуулийнхаа бүжгийн хамтлагийн гишүүн. Өдгөө он жавууддаа бүжиг зааж байгаа гэнэ.

Нэгнийхээ зан араншинг тодорхойлооч гэхэд Э.Дэлгэрэхзаяа нь "Ихэр маань их хөгжилтэй. Хүмүүсийг хөгжөөж, нөхөрсөг уур амьсгалыг дандаа бүрдүүлж байдаг юм. Тэр миний итгэж явдаг хамгийн сайн найз. Түүнээс юугаа ч нуудаггүй. Дорноговь аймаг руу бүтээн байгуулалтад явахад нь бага зэрэг санасан. Бид хоёр ингэж салж байгаагүй юм" гэсэн бол Э.Дээдлэхзаяа "Дэлгэрэх маань их даруухан, төлөв томоотой. Гэхдээ гэртээ бол даруухан байдаггүй, бид хоёр ноцолдож өгнө шүү дээ. Хичээлдээ их сайн, номонд дуртай гэж жигтэйхэн. Ихрийгээ би хэзээ ч, хаана ч хамгаална" гэсэн нь дотно сайхан сонсогдлоо. Ихрүүд 2019 оны шилдэг байлдагч нарын шинэ жилд оролцсоноо ч бас хуучилж, анги хамт олноо бүтээн байгуулагчид гэж магтаж байв. Тэд цэргийн албанаас эх орноо хайрлах үзэл, цэргийн албаар бахархах сэтгэлийг олж авснаа ярианыхаа төгсгөлд онцолсон юм.

Дэслэгч Д.БОЛОРМАА

Хүчингүйд тооцов

У.Отгонбаяр, Э.Очбадрах, Б.Анхбаяр, Э.Батцоож, Д.Уранчимэг, Э.Хашбадрах, З.Багахүү, Г.Бишрэлт, Г.Төмөрчөдөр, П.Энхбаяр, М.Каеш, Б.Баяржаргал, Э.Мөнхбат, Н.Батдорж, Б.Золбаяр, Б.Равжих, Б.Өсөхбаяр, Д.Отгонбаяр, Д.Баяраа, Б.Болдбаатар, Б.Балжинням нарын офицерын Д.Манлайбаатар, Б.Амартөр, Б.Ууганбаатар, үнэмлэх, Б.Билэгдэмбэрэл, Г.Эрдэнэбаатар, П.Даваасамба, Ц.Ууганбаяр, Ц.Нямдаваа нарын ахлагчийн үнэмлэх, ЦАБ-2209, ЦАБ-6151 дугаартай авто машины гэрчилгээг тус тус хүчингүйд тооцов.

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 95 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Шинэ ном

БҮСГҮЙ ХҮНИЙ ЭРХЭМ ОРШИХУЙ

Японы "Шоова" охидын их сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, ерөнхийлөгч Бандоо Марикогийн "Бүсгүй хүний эрхэм оршихуй" (Гадаад үзэмжээс амьдралын хэв маягт) ном монгол хэлээр хэвлэгдлээ. Энэ ном боловсрол, ажил хэргээс эхлээд хувцаслалт, амьдрах хэв маяг, хайр сэтгэлд хүртэл эмэгтэй хүнийхээ хувиар үзүүлэх ааш аягийг зөвлөж, даяаршиж буй нийгэм дэх эмэгтэйчүүдийн ахуй амьдрал, соёл, бүсгүйчүүдийн асуудал руу хүчээ сорьж үзэх, манлайлагчийг бэлтгэж сургахад ач холбогдолтой юм.

Тус ном нь хэвлэгдэхтэйгээ зэрэгцэн Японы нийгмийн анхаарлын төвд орж, борлуулалтаараа тэргүүлжээ. Номынхоо эх бичвэрт оногдох орлогоороо суурь хөрөнгө босгож гурван зуун сая хол давсан иенийг хандивлаж Бандоо Марико санг байгуулсан аж. Сангаас "Шоова" охидын их сургуульд сурдаг гадаад оюутнуудын тэтгэлэг болон мэргэжил гориллох шалгалтын төлбөр, эмэгтэйчүүдийн Соёл судлалын нэрэмжит шагналыг бий болгоод байна.

"Интерном" номын их дэлгүүрт "Бүсгүй хүний эрхэм оршихуй" номын нээлтийн ёслол болов. Номыг монгол хэлээр хэвлүүлэх төслийг санаачлагч, доктор Боржигоны Хүсэл энд хэлсэн үгэндээ "Хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх нийгмийг бүтээхийн төлөө хувь нэмрээ оруулах, эмэгтэйчүүдийн хөгжил дэвшилд Бандоо Марико сангаас дэмжлэг үзүүлж ирсэн. Монгол хүмүүс ч төсөл бичиж илгээвэл энэ сангаас дэмжигдэх боломжтой" гэж өгүүлэв.

Тус номыг ариусган шүүсэн Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Д.Цэдэв "Эмэгтэй хүн өөрийгөө нээх, Японд амьдарч суралцахаар одож буй хүмүүст энэ орны соёл, иргэншлийн онцлогийг танин мэдэхэд гарын авлага болсон бүтээл" гэдгийг онцлон дурдлаа. Мөн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Урангуа "Монголын эмэгтэйчүүд судлалаар ажилладаг хүмүүс асуудлыг их томоор авч үздэг. Монголын түүхэнд, төрт ёсонд ... гээд өргөн хүрээнд хөндөж ирсэн. Харин энэ номыг эмэгтэй хүн өөрөө хэрхэн эрхэмсэг байвал хүмүүст хүлээн зөвшөөрөгдөх вэ гэдэг өнцгөөс туурвижээ. Японд гурван сая давсан борлуулалттай энэ ном Монголд ч үнэ цэнтэй хэвээр байна гэдэгт итгэж байна" гэдгээ илэрхийлэв.

Номыг зохиогч Бандоо Марико Японы Ерөнхий сайдын Хэрэг эрхлэх газрын зөвлөх, Статистик судлалын газрын хэрэглээний статистикийн хэлтсийн дарга, Хүйсийн тэгш байдлыг ханган оролцуулах газрын дарга, Сайтама аймгийн Засаг дарга, Австралийн Брисбэнд байрлах Японы ЭСЯ-ны Ерөнхий консул зэрэг албыг хашиж одоогийн албан тушаалд томилогджээ. Тэрээр номынхоо төгсгөлийн бүлэгт "Хүнд байх үндсэн чадвар гэж юу вэ" гэсэн асуултад өөрийн чинь үйлдэл, амьдрах аргын тулгуур болох итгэл үнэмшил юм. Шагнал урамшуулал хүлээлгүйгээр хийх ёстойгоо хэрэгжүүлэх, гарз хохирол учирсан ч зөвийг хийх тэнхээ гэж бас хэлж болох юм. Мөн бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх чадвартай байх, зөвж зүдэрсэн дорой нэгэндээ гар сунгаж тусалж чаддаг байх, хүний төгс бус, сул байдлыг хүлээн авах халуун дулаан сэтгэл, байгалийн гоо үзэмж, эрүүл саруулд сэтгэлээ хөдөлгөх уян зөөлөн араншинтай байх нь их чухал шүү" гэж зөвлөсөн байна.

МУИС-ийн багш Э.Тогтуун энэхүү номын орчуулгыг хийж "Шоова" охидын их сургуулийн судалгааг дэмжих төслийн хүрээнд хэвлүүлэн Монголын уншигчдын гэгээн мэлмийд өргөн бариллаа.

Бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ

ЭМГҮЙГЭЭР ХАНИАД, ТОМУУГ ЭДГЭЭХ 13 АРГА

Хүйтний улирал ид дундаа орж байгаа энэ үед томуу төст өвчний дэгдэлт их байна. Энэ үед хүмүүсийн биеийн дархлаа суларч ханиаданд нэрвэгдэх нь элбэг болдог. Тэгвэл эм тариа, эмчид хандалгүй гэрийн нөхцөлд ханиадаа хэрхэн эмчлэх вэ?

Танд хэрэгтэй 13 зөвлөгөө хүргэе.

1.Ханиадны шинж тэмдэг илрэнгүүт аль болох гэртээ өнжих нь зохимжтой. Өвчний эхний үед бие организмд амар тайван байдал чухал. Тиймээс сайн унтаж амар.

2.Бүлээн шингэн зүйл байнга уу. Энэ нь зөгийн бал юм уу нимбэгтэй цай, аньсны буурц байвал зохимжтой.

3.Хамраа давсны уусмалаар угаа. Цайны халбагаар тал давсыг нэг аяга буцалсан бүлээн усанд уусгаад 3-4 удаа хамартаа соруулж зайлна.

4.Халуун усанд орох нь ч тустай. Гэхдээ ханиад дөнгөж эхэлж байгаа үед буюу халуунгүй үедээ гэдгийг тооцоолоорой.

5.Өрөө тасалгаандаа агаар оруул. Ханиад хүрсэн үед цэвэр агаар маш чухал.

6.Зөв хоолло. Тахиа болон загасны шөл, шинэхэн жимс, ногоо идэх нь тустай. Хэрвээ таны хоолой хөндүүрлээд залгихад хүндрэлтэй байгаа бол жимс, ногооны шинэхэн шүүс уу.

7.Дарсан үедээ хагас аяга халуун усанд таван дусал иод хийж, хутгаад уу. Мөн иодийг шууд хамрын нүхээр ээлжлэн үнэрлэж болно.

8.Хүрэн манжинг чанаж, шүүсийг нь халуунаар уу.

9.Архаг ханиадны үед шар будааг буцалгаж, бүлээн шүүсээр нь хамраа зайлж угаана.

10.Хий ханиадыг эмчлэхийн тулд сонгино, саримсыг хольж жижиглээд, түүхий сүүнд хийн зөөлөртөл нь буцалгана. Дараа нь бага зэрэг гаатай ургамал, зөгийн бал нэмж хийнэ. Бэлдмэлээсээ цаг тутам нэг халбага ууна.

11.500 грамм сүүг бага зэрэг халааж, дотор нь нэг ширхэг өндөг хийгээд хутгана. Дээрээс нь цайны халбага зөгийн бал, хоёр цайны халбага цэцгийн тосыг нэмээд сайтар хутгаарай. Ингэж бэлтгэсэн сүүг орой унтахын өмнө ууна.

12.Чацаргана, аарцыг сайн ууж хэвших хэрэгтэй.

13.Нэг грамм аскорбины хүчлийг өглөө бүр цайныхаа дараа уугаарай.

Цэргийн төв эмнэлгийн ЦХХМЗТ-ийн сувиллагч Ц.ТҮМЭНДЭЛГЭР



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 95 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029